

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР



2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2021.01.04

АГУУЛГА

<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэмжээний хэрэгжилт Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл</p>	<p align="center">3-4</p>
<p>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт Нийслэлийн Засаг даргаас зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил</p>	<p align="center">5</p>
<p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт Архив, албан хэрэг хөтлөлт Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа Төсөв, санхүү, орлого бүрдүүлэлт “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ</p>	<p align="center">6-83</p>
<p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ Үйл ажиллагааны ил тод байдал Хүний нөөцийн ил тод байдал</p>	<p align="center">84- 86</p>
<p>ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар</p>	<p align="center">86 - 96</p>

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар нь тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”, Агаарын тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар:

- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1 зорилт бүхий 3 арга хэмжээний 4 заалтын хэрэгжилтийг 85%,
- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилт 4 арга хэмжээний 13 заалтын хэрэгжилтийг 92.3%,
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилт бүхий 2 арга хэмжээний 6 заалтын хэрэгжилтийг 86,6%-тай ханган биелэлтийг нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээ хийж 85 хувьтай биелсэн гэж дүгнэн байгууллагын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлцүүлэн хурлын тэмдэглэлийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын А/10, А/52, А/346, А/115, /828, А/748, А/197, А/208, А/780-А/322, А/374, А/715, А/109, А/667, А/779, А/382, А/276 дугаар захирамжийн биелэлтийг хугацаанд нь оруулж ажилласан.
- Нийслэлийн онцгой комиссын 8 дугаар хурлын тэмдэглэл <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 01-04, 01-06, 01-06а, 02-03, 02-04 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг гарган цаасаар болон <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.
- Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн үүрэг даалгаврын 46 удаагийн 169 хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг цаасаар болон <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.
- Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/483 дугаар захирамжийн хавсралтаар баталсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах мэдээний ангиллын дагуу тус газар холбогдолтой мэдээллийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гарган НЗДТГ-ын төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/382 дугаар захирамжийн хэрэгжилтийн биелэлтийг УБЗАА-д албан бичгээр хүргүүлсэн.
- 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдөр 42 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг холбогдох газарт хүргүүлсэн.
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021 оны хэрэгжилтийн явцын тайланг НЗДТГ-ын ХБТХ-т албан бичгээр хүргүүлсэн.
- Монгол Улсын засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу байгууллагын 14

-
- хоногийн үйл ажиллагааны тайланг тогтмол НЗДТГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/1286 дугаар захирамжийн хэрэгжилтийг нэгтгэн НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.
 - Улсын Их Хурлын 2019 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.
 - Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/242 дугаар тушаалаар батлагдсан уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2-р шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн НЗДТГ-ын ХШҮХ-т албан бичгээр хүргүүлсэн.
 - МУ-ын ерөнхий сайд, ЗГХЭГ-ын даргын нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд онцгой анхаарч ажиллах үүрэг чиглэл өгсний дагуу хэрэгжилтийг 2021 оны хагас жилийн байдлаар гарган НЗДТГ-ын төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.
 - Байгууллагын авилгын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар гарган НЗДТГ-т албан бичгээр хүргүүлсэн.
 - Захирагчийн шуурхай 2021 оны 01 дүгээр сарын 29-ноос хойш Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор хойшлогдоод байна.
 - Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021 онд Байгал орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн биелэлт, 2022 онд хамтран ажиллах гэрээний арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналын хамт НЗДТГ-ын ХБТХ-т албан бичгээр хүргүүлсэн.
 - Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны “Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 19/03 дугаар тогтоолын 1.3-т тусгагдсан “Зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс илүү бохирдуулах бодис ялгаруулж байгаа болон утааны шүүлтүүргүй дизель хөдөлгүүртэй автобус, ачааны автомашиныг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Нийслэлийн замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажиллах” заалтын хүрээнд тус газраас авч хэрэгжүүлсэн ажлын тайланг НЗДТГ-ын ХБТХ-т албан бичгээр хүргүүлсэн.
 - Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтийг УБЗАА-д албан бичгээр хүргүүлсэн.
 - Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус газарт хамаарал бүхий арга хэмжээний биелэлтийг Нийслэлийн Онцгой байдлын газарт албан бичгээр хүргүүлсэн.
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 365 хоногт хийсэн ажлын тайланг НЗДТГ-ын ХБТХ-т албан бичгээр хүргүүлсэн.
 - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн шуурхай зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.
 -

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

а) Байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа Монгол Улсын хууль тогтоомж ийн 2 шийдвэрийн 15 заалт, Монгол Улсын Их хурлын тогтоолын 1 шийдвэрийн 4 заалт, УИХ-ын Байнгын хорооны тогтоолын 1 шийдвэрийн 2 заалт, Засгийн газрын тогтоолын 2 шийдвэрийн 10 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 2 шийдвэрийн 3 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 1 шийдвэрийн 5 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолын 1 шийдвэрийн 1 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийн хувийг тооцон жилийн эцсийн байдлаар гарган даргын дэргэдэх хурлаар хэлцүүлэн танилцуулгын хамт НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

б) Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухайд нь гарган ажиллаж байна. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 4 дүгээр улирлын байдлаар нийт 26 удаагийн 101 заалтын биелэлтийг нэгтгэн гаргаж НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ulaanbaatar.mn сайтад байршуулсан.

Хүснэгт-1

Хууль, тогтоомж шийдвэрийн биелэлтийг хүснэгтээр харуулав.

д/д		Нийт	Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын БХ-ны Тогтоол	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол	НИТХ-ын хуралдааны тэмдэглэл
1	Нийт шийдвэрийн тоо	36	15	4	2	10	3	1	1
2	Нийт заалтын тоо	36	15	4	2	10	3	1	1
3	Бүрэн хэрэгжсэн	100	28	13	3	9	2	0	-
4	Хэрэгжиж байгаа	70	6	1	1	1	-	1	1
5	Эрчимжүүлэх шаардлагатай	30	1	-	-	-	1	-	-
6	Хэрэгжээгүй	0	-	-	-	-	-	-	-
7	Үүнээс	Зохион байгуулалтаас шалтгаалсан	0	-	-	-	-	-	-
8		Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан	0	-	-	-	-	-	-
9	Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй		1	1	-	-	-	-	-
10	Гүйцэтгэлийн хувь		83,2	91,3	92,5	85	97	76,6	70
11	Үнэлгээний хувь		83,2	91,3	92,5	85	97	76,6	70

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох ажлын хүрээнд:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх, Олон Улсын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлэх бэлтгэх ажлыг хангах хүрээнд Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2018 нэвтрүүлэх сургалтыг төсвийг “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрт суулгаж, байгууллагын 2021 оны сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу газрын даргын 2021 оны А/109 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулж, сонгон шалгаруулалтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр сонгон шалгаруулж, албан хаагчдын дунд ISO9001 стандартын талаар анхан шатны ойлголтыг өгөх сургалтыг зохион байгуулан ажиллаа.


3.2 Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо сонгон шалгаруулсан НАБТГ/2021-05 дугаартай “**Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, зөв дадал хэвшилд сургах сургалт зохион байгуулах**” ажлын хүрээнд Агаар орчны бохирдлыг бууруулахад өсвөр үе, оюутан залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, өсвөр үе, оюутан сурагчдад агаарын бохирдлын хор хөнөөлийн талаар мэдлэг олгох, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл өгөх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилготой нийслэлийн төвийн 6 дүүргийн гэр хорооллын сургуулийн 900 сурагчид, 300 оюутан залуучуудад сургалт зохион байгуулсан.

Тус ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллага “OUR IMPACT”-аяныг зохион байгуулж, аяны хүрээнд агаарын бохирдлын талаар хүүхэд залуучуудад мэдээлэл өгөх зорилгоор цуврал мэдээ, постер бэлтгэж “Карл попперын нийгэмлэг” фэйсбүүкийн пэйж, хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэсэн. Мөн сургалтын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:


- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд 1200 сурагч, 300 оюутанд 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрүүдийн хооронд 4 өдрийн турш 8 удаагийн сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан.
- Сургалтад хэрэглэх “Агаар орчны бохирдол” гарын авлагын эхийг бэлтгэж хүүхэд, залуучуудыг мэдээллээр хангасан.
- Агаар, орчны бохирдол, угаарын хий хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замуудын талаар мэтгэлцэн хэлэлцэх замаар шинэ санаа дэвшүүлж шийдэл олох боломжийг өсвөр үе, сурагч, оюутнуудад олгох зорилготой 70 багийн 210 залуучуудыг хамарсан мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулсан
- Мөн хүүхэд залуучуудын дунд “Агаар, орчны бохирдол, угаарын хийн эрсдэлээс сэргийлэхэд миний нөлөөлөл” сэдэвт гар зургийн уралдаан, эссэ бичих уралдаан зарлаж шагналт байруудыг шалгаруулсан.

- Зурагт постер түгээх ажлын хүрээнд нийтдээ 44 ширхэг постерыг тус тус бэлтгэн цахим орчноор дамжуулан өсвөр үе, залуучуудад хүргэсэн.



Зураг 1 “Карл попперын нийгэмлэг” фэйсбүүкийн хуудсаар мэдээлэл хүргэж буй байдал, гарын авлага

“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сэтгүүлчдийн нэгдсэн холбоотой хамтран “Агаарын бохирдлыг бууруулахад сэтгүүлчдийн үүрэг оролцоо” чуулга уулзалтад оролцох 1000 сэтгүүлчдэд мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах, чуулга уулзалтын хүрээнд агаарын бохирдлыг бууруулахад иргэдийг уриалсан 3 минут 26 секундын видео шторк, “Та өвөлдөө бэлэн үү” 1 минут 11секундын, “Өнтэй өвөлжье” өдөрлөгт зориулсан иргэдийг уриалсан 1 минут 52 секундын видео контент бэлтгэж байгууллагын албан ёсны вэбсайт <http://www.aprd.ub.gov.mn/>, фэйсбүүкийн пэйж хуудас Агаарын бохирдолтой тэмцэх газар, хамтран ажилладаг 14 цахим хуудас, Ийгл, UBS телевизүүдээр дамжуулан нийт 65857 хүнд хүргэж ажилласан.



Зураг 2. Видео шторк, хүнд хүрсэн байдал

“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил, дэвшилтэт техник технологийг олон нийтэд мэдээлэх, видео шторк, постерын эх бэлтгэх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөөг иргэдэд хүргэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулахаар 4 аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан мэдээллээр ханган хамтран ажиллаж байна.

“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүрээнд байгууллагын вэбсайтыг MNS 6285:2017 стандартын шаардлагад нийцүүлж шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх, байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд хүргэх, байгууллагын брэндбүүк хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, гэрээний гүйцэтгэлд хяналт тавин хамтран ажиллаж байна.

Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж иргэд, олон нийтэд мэдээлэл өгч сэрэмжлүүлэг хүргэх ажлын хүрээнд видео шторкын зохиолыг бичиж батлуулан 3 минутын сэрэмжлүүлэх видео шторк бэлтгэсэн.

Тус шторкыг байгууллагын www.aprd.ub.gov.mn, цахим хуудас, Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэдээ фэйсбүүкийн цахим хуудас, хамтран ажилладаг 10 сайтаар цацаж олон нийтэд хүргэж байна. Мөн TV-25, TV-8 телевизээр өдрийн 4-өөс доошгүй давтамжтайгаар 05 дугаар сарын 01 хүртэл нэвтрүүлж олон нийтэд хүргэсэн.



Зураг 3. Угаарын хийн эрсдэлээс сэргийлэх видео шторк

Нийслэлийн Засаг даргын орлогч бөгөөд Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөөгийн өгсөн чиглэлийн дагуу 32-ын тойргийн авто зам дагуу орчны агаарын чанарын хэмжилтийн үеэр Mass tv, Zasagtur.mn вэбсайтаар ярилцлага, нэвтрүүлэгт ахлах мэргэжилтэн М.Отгонбаярыг оролцуулсан.



Зураг 4. Агаарын чанарын хэмжилт хийж буй нэвтрүүлэг Mass tv телевиз, Zasagtur.mn вэбсайтаар гарч буй байдал

Монголын Үндэсний радио телевизийн цагийн хүрд нэвтрүүлэг, Налайх дүүргийн агаарын чанар хэмжих шууд лайв нэвтрүүлэгт ахлах мэргэжилтэн М.Отгонбаярыг оролцуулж мэдээллээр хангаж ажилласан.

Нам даралтын зуухыг хийн халаалтын зуухаар сольсон Ерөнхий боловсролын 129 дүгээр сургуулийн орчинд агаарын чанарын хэмжилт хийсэн 7 минут 30 секундын нэвтрүүлэгт НАБТГ-ын дарга Б.Пүрэвсүрэн, ахлах мэргэжилтэн М.Отгонбаяр нарыг оролцуулж мэдээлэл өгсөн.

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31,1 дэх заалт, “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу 2021 оны хаврын “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан TV-25 телевизийн “25 цаг мэдээллийн хөтөлбөр”-т Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга Б.Пүрэвсүрэнгээр мэдээлэл өгч оролцуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/1253 дугаар захирамжийн хүрээнд батлагдсан удирдамж, мэдээлэл, сурталчилгааны ажлыг хамтран хэрэгжүүлэх байгууллагуудын жагсаалтыг үндэслэн 17 аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулан гэрээг дүгнэн хамтран ажилласан.

Тус ажлын хүрээнд байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлыг олон нийтэд хүргэх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой 50 ширхэг постер, 4 нэвтрүүлэг, 8 видео шторкыг бэлтгэж 2 телевиз, 10 сайт, өглөөний сониноор дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.



Видео шторк түгээсэн байдал

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31,1 дэх заалт, “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу 2021 оны хаврын “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан TV-25 телевизийн “25 цаг мэдээллийн хөтөлбөр”-т Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга Б.Пүрэвсүрэнгээр мэдээлэл өгч оролцуулсан.

Ийгл, UBS, ТМ, ТВ-8, NTV телевизээр угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлын эх үүсвэр, байгууллагын зүгээс хийж хэрэгжүүлж буй ажил, сайжруулсан шахмал түлш нөөцлөлт, агаарын чанарын талаар нийт 8 ярилцлага, мэдээллийн хөтөлбөрт албан хаагчдыг оролцуулсан. Мөн Zarig.mn, <http://dardas.mn/news/view/21457>, <https://gogo.mn/r/q0nqy>, <https://ergelt.mn/news/118/single/15136>, <https://www.ubn.mn/p/20151> зэрэг 10 сайтаар олон нийтэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэсэн.

Зураг 5.






Ийгл, UBS, TM, ТВ-8, NTV телевизээр угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлын эх үүсвэр, байгууллагын зүгээс хийж хэрэгжүүлж буй ажил, сайжруулсан шахмал түлш нөөцлөлт, агаарын чанарын талаар ярилцлага өгсөн байдал

“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил, дэвшилтэт техник технологийг олон нийтэд мэдээлэх, видео шторк, постерын эх бэлтгэх, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөөг иргэдэд хүргэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулахаар 4 аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан мэдээллээр ханган хамтран ажилласан.

НАБТГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны сонгон шалгаруулсан “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүрээнд “Байгууллагын вэбсайтыг MNS 6285:2017 стандартын шаардлагад нийцүүлж шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд хүргэх”, ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Тус ажлын зорилго нь байгууллагын ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, мөн байгууллагын вэбсайтыг MNS 6285:2017 стандартын шаардлагад нийцүүлж шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зураг 6.



Хуучин вэбсайт

Шинэ вэбсайт

Мөн тус ажлын хүрээнд байгууллагын логог шинэчилж хэвлэлтийн стандартад нийцүүлж шинэчилсэн.

Зураг 7.



Лого шинэчлэж стандартад нийцүүлсэн байдал

Агаарын бохирдлыг бууруулах, авто машины утаа, өнтэй өвөлжих мэдээлэл, зөвлөгөө өгөх постер 4 ширхгийг бэлтгэж байгууллагын албан ёсны вэбсайт <http://www.aprd.ub.gov.mn/>, фэйсбүүкийн пэйж хуудас Агаарын бохирдолтой тэмцэх газар, хамтран ажилладаг 4 цахим хуудаснуудаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.

Зураг 8.



Постер хэвлэгдсэн байдал

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлье” аяныг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан.

Тус аяны хүрээнд 9 төрлийн угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжүүлэн ажилласан. Үүнд:

Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 10 цуврал постер бэлтгэж байгууллагын албан ёсны вэбсайт <http://www.aprd.ub.gov.mn/>, Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, <https://ulaanbaatar.mn/> Нийслэлийн мэдээ фэйсбүүкийн цахим хуудас, хашаандаа сайхан амьдаръя цахим групп, хамтран ажилладаг 4 сайтаар дамжуулан давхардсан тоогоор нийт 50,000 гаруй хүнд хүргэж ажилласан.



Постер

- MGL радио 88.3, 91,1 FM радиогоор угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 5 төрлийн зөвлөмжийг олон нийтэд хүргэж ажилласан.
- Угаарын хийн эрсдэлээс сэргийлэх 4 төрлийн мессэжийг үүрэн телефоны операторуудаар дамжуулан хүргэсэн.
- Угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий стикер, хулдаасан хэвлэлийг автобусны буудал, зам дагуу байрлах самбарт байршуулан иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Зураг 10.



Зөвлөмж, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал

- Гэр хорооллын сургуулиудын мэдээллийн самбарт 6 төрлийн 600 ширхэг угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас байршуулсан.
- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, зорилтот бүлгийн 10,000 айл өрхийн янданг хөөлсөн.
- НОБГ-ын салбар нэгжүүдийн хэмжээнд ажилладаг болон дүүргүүдийн хог тээвэрлэгч байгууллагуудын техник хэрэгсэл, машин механизмаар угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг зарлан мэдээллэсэн.
- Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгүүдээр зөв галлагааны зөвлөмжийг байршуулж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.

Мөн угаарын хийн эрсдэлээс сэргийлэх 3 төрлийн видео контентыг Ийгл, NTV, UBS, Монголын Үндэсний телевизээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн.

Ийгл, UBS, TM, ТВ-8, NTV телевизээр угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлын эх үүсвэр, байгууллагын зүгээс хийж хэрэгжүүлж буй ажил, сайжруулсан шахмал түлш нөөцлөлт, агаарын чанарын талаар нийт 8 ярилцлага, мэдээллийн хөтөлбөрт албан хаагчдыг оролцуулсан. Мөн Zarig.mn, <http://dardas.mn/news/view/21457>, <https://gogo.mn/r/q0nqy>, <https://ergelt.mn/news/118/single/15136>, <https://www.ubn.mn/p/20151> зэрэг 10 сайтаар олон нийтэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэсэн.

3.3 Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу Нийслэлийн ЗДТГ-ын хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн <https://www.ulaanbaatar.mn/>, “Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар”-ын албан ёсны цахим хуудас <http://aprd.ub.gov.mn/>, болон Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, хамтран ажилладаг 14 сайт, 2 телевиз, Өглөөний сониноор байгууллагын үндсэн үйл ажиллагаа, бодлого, удирдлагуудын шийдвэр, хийж буй ажлын талаарх мэдээ мэдээллийг тогтмол

шинэчлэн түгээж, олон нийтэд үнэн бодитоор, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан, иргэдийн мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна.

Тус тайлант хугацаанд нийт 64 мэдээ бэлтгэн нийтэлсэн бөгөөд Covid 19" цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар 4, байгууллагаас хийгдсэн хэмжилт, хийж хэрэгжүүлсэн ажлын талаар 14, сайжруулсан түлшний борлуулалтын цэг, түгээлтийн талаар 17, бусад төрлийн 29 төрлийн мэдээ бэлтгэн байгууллагын ил тод байдал, байгууллагаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг олон нийтэд хүргэж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагатай холбоотой буруу ташаа мэдээлэл гараагүй болно.

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн мэдээлэл технологийн газартай хамтран вирусны программын лицензийн хугацааг сунгах шаардлагатай 24 компьютерт вирусны программ суулгасан.

Зураг 12.



Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан ёсны сайм <http://aprd.ub.gov.mn/> болон Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудсаар мэдээлэл тавигдсан байдал

3.4 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд:

Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор “Жайка ОУ-ын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа “Агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-3”-ын хүрээнд 5 удаа онлайн хурал зохион байгуулсан. Энэхүү хурлуудаар төслийн явцыг хэлэлцэж, хоцрогдолтой ажлуудыг хэрэгжүүлэх хуваарьт өөрчлөлт оруулах, Улаанбаатар хотын агаарын бохирдуулах эх үүсвэрүүдэд томоохон өөрчлөлт орсонтой холбоотойгоор эх үүсвэрүүдийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох судалгааг ЦУОШГ-тай хамтран хэрэгжүүлэх, НАБТГ-ын хөдөлгөөнт эх үүсвэр хариуцсан 2 мэргэжилтэнд АСХУХ-ын ур чадвар эзэмшүүлэх сургалт, 1-2 мэргэжилтэнд тархалтын загварын сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах, сайжруулсан түлшний туршилтын төсөл хэрэгжүүлэх байршил сонгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн.

- Азийн орнуудын агаарын чанарыг сайжруулах нэгдсэн хөтөлбөр төслийн хүрээнд 8 орны 53 оролцогчтой цахим сургалтанд ахлах мэргэжилтэн М.Отгонбаяр оролцож, 6 асуулгад санал өгсөн. Японы Жайка олон улсын байгууллагаас 2021.05.12 өдөр зохион байгуулсан “Эх үүсвэрээс үүдэлтэй агаар бохирдуулагч бодисын ялгарлыг тооцох” цахим сургалтад тус хэлтсийн 3 мэргэжилтэн оролцсон. Сургалтаар автомашинаас үүдэлтэй бохирдуулагч бодисын ялгарлыг хэрхэн тооцоолох, үйл ажиллагааны өгөгдөл хэрхэн цуглуулах, мөн ялгарлын коэффициент тооцоолоход шаардлагатай мэдээллийг нэгтгэх,

боловсруулах зэрэг арга зүйн болон техникийн чадвараа нэмэгдүүлэн, цаашид бие даан тооцоолол хийх чадварыг эзэмшиж байна. Төслийн зорилгыг биелүүлэх явцад Орчны агаар болон бохирдуулах бодисын ялгарлын эх үүсвэрийн хяналт шинжилгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн үнэлгээ, Агаарын бохирдлыг бууруулах стратеги, бодлого, шийдвэр, хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт гэсэн 4 шатлал бүхий агаар орчны хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллана.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас техникийн туслалцаагаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” (3-р үе шат)-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Уг төслийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 09-өөс 10-ны хооронд Жайка төслийн автомашины хаягдал утааны хэмжилт хариуцсан ажилтан Окабэ Жюн хамтран /АСХУХ/ төхөөрөмжийг ашиглан хэмжилт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Автомашинд суурилуулдаг хаягдал утаа хэмжигч (АСХУХ) үр дүн боловсруулах сургалтын дагуу хамгийн эхний хэмжилтийн дүнг боловсруулан гаргасан. Хэмжилтэд дизель хөдөлгүүрт нэг тээврийн хэрэгсэл ашигласан. Хэмжилтийн дүнгээр автомашин хөдөлгөөнд жигд хурдтай оролцох үед ялгарах Хүхрийн давхар исэл (SO₂) ; Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) хэмжээ ялгарал бага байсан бол хурд ихтэй болон удаан оролцож байх үед ялгарал ихсэж Хүхрийн давхар исэл (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) ихээр ялгарч байгаа үзүүлэлттэй байсан.

Мөн 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Төслийн багийн дэд дарга Саваки Нацужи суурин эх үүсвэрийн хэмжилтийн хүрээнд мэргэжилтэн бэлтгэх, багаж тоног төхөөрөмж засварлах талаар сургалт зохион байгуулж тус газрын оператор, техникч У.Жаргалбаатар, Э.Энх-амгалан, С.Алтансүх нар хамрагдсан.

3.5 Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд мониторинг хийх чиг үүргийн хүрээнд:

3.5.1 Суурин эх үүсвэрийн хэмжилтийн Maruni science болон суурин харуулын тоосонцрын EDM-180, APDA-371, APSA-370 багажнуудыг Япон болон Герман улс дахь үйлдвэрлэгч рүү илгээж, батлагаат засвар үйлчилгээг хийлгүүлнэ.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах үйл ажиллагаанд хяналт тавих, агаарын бохирдлыг бууруулах ажлын үр дүнг тодорхойлдог хэмжилтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, хэмжилтийн баталгаа, нарийвчлалыг хангах зорилгоор 4 нэр төрлийн 5 ш багаж төхөөрөмжүүдийг тээвэр зуучийн “Ди Эйч Эл” ХХК-тай 5,894,390 төгрөгийн гэрээ байгуулан Япон болон Герман улс дахь үйлдвэрлэгчийн газарт илгээж засварлуулахаар багажнуудыг илгээсэн.

Багажнууд үйлдвэрүүддээ хүргэгдсэн бөгөөд засварын гэрээний төслийг илгээгээд байна. Ажлын гүйцэтгэл 100%

Хүснэгт-2

№	Багажны нэр	Марк	Зориулалт	Ашиглалтын байдал	Засварт илгээгдсэн тоо хэмжээ	Үйлдвэрлэгч улс /илгээгдсэн	Засварын гэрээний явц
---	-------------	------	-----------	-------------------	-------------------------------	-----------------------------	-----------------------

						улс/	
1	Maruni	NGZ-5DK	Хаягдал утаан дахь тоосонцор тодорхойлно	Суурин эх үүсвэр	1	Япон	Гэрээний төсөл боловсруудагдаж, илгээгдсэн /Япон/
2	Horiba	APSA-370	Орчны агаар дахь хүхрийн давхарисэл тодорхойлно	Толгойтын суурин харуул	1	Япон	Гэрээний төсөл Монгол дахь гэрээт байгууллагаас хүлээгдэж байгаа
3		APDA-371	Орчны агаар дахь тоосонцор тодорхойлно	Баянхошууны суурин харуул	1	Герман	Гэрээний төсөл Монгол дахь гэрээт байгууллагаас хүлээгдэж байгаа
4	EDM	EDM-180	Орчны агаар дахь тоосонцор тодорхойлно	Хөдөлгөөнт AQMS-9000 /32-65УБП/ харуул	2	Герман	Гэрээний төсөл боловсруудагдаж, илгээгдсэн /Англи/
Нийт засварт илгээгдсэн багаж					5	Багажны тээврийн зардалд талдаа 5,894,390 төгрөг зарцуулсан.	

3.5.2 Суурин харуулын сэлбэг хэрэгслийг худалдан авч, солих, ЦУОШГ-тай хамтран суурин харуулын хэмжилтийн багажнуудад хийн тохиргоо хийж, баталгаажуулна.

1. Байгууллагын 2021 онд нэг суурин харуул дээр дунджаар 20 удаа очиж засвар үйлчилгээ, хяналт хийж ажилласан. Суурин харуул тус бүрээр авч үзэхэд Баянхошуу суурин харуул дээр 18, Толгойт суурин харуул дээр 22, Нисэх суурин харуул дээр 20, Амгалан суурин харуул дээр 16, МҮОНРТ суурин харуул дээр 18 удаа тус тус очиж ажилласан.

2. 2021 оны 05 дүгээр сарын 11-ний өдөр ЦУОШХ болон Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга Г.Даваажаргал нар суурин харуул тус бүр дээрх Озоны багажуудыг ЦУОШХ-ийн лаборатори дээр хийн тохируулга цэвэрлэгээ хийх, баталгаажуулах үүрэг өгсний дагуу Амгалан суурин харуул болон МҮОНТ-ийн суурин харуулын Озоны багажуудын хийн тохируулга баталгаажуулалтыг хийсэн.

3. Байгууллагын хэмжилтийн үйл ажиллагаанд ашиглагддаг тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, Улаанбаатар хотын агаар бохирдуулах үйл ажиллагаанд хяналт тавих, агаарын бохирдлыг бууруулах ажлын үр дүнг тодорхойлдог хэмжилтийн нарийвчлалыг хангах зорилгоор Баянхошууны суурин харуулын тоосонцрын APDA-371 1 ширхэг, Толгойтын суурин харуулын APSA-370 1 ширхэг, Суурин эх үүсвэрийн тоосонцрын дээж авах зориулалттай Maruni 1 ширхэг, суурин харуулын хэмжилтийн зориулалттай EDM-180 багаж 2 ширхэг, нийт 5 хэмжилтийн багаж төхөөрөмжийг Япон болон Герман улс дахь үйлдвэрлэгчийн газар руу илгээж, засварлуулахаар тээвэр зуучийн "Ди Эйч Эл" ХХК-тай 5,894,390 төгрөгийн гэрээ байгуулан багаж төхөөрөмжийг илгээсэн.

4. Засвар үйлчилгээ хийгдсэн суурин харуулын хэмжилтийн зориулалттай EDM-180 2 ширхэг багажнуудыг хүлээн авч, Толгойт, Амгалангийн суурин харуулуудад суурилуулсан. Засварын үнийн дүн 17,4 сая төгрөгийг үйлдвэрлэгчид шилжүүлсэн.

5. Толгойтын суурин харуулын хүхрийн APSA-370 багажийг Герман улс, тоосонцрын APDA-71 багажийг АНУ-д үйлдвэрлэгчийн дистербютр компани болох "Интерсайнс" ХХКтай засварын гэрээ байгуулж, засварын үнийн дүнд 72.9 сая төгрөгийг, Япон улс руу суурин эх үүсвэрийн хаягдал утааны хэмжилтийн Maguni багажийг илгээж, засварын үнэд 5,1 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн.

6. СБД-ийн 16 дугаар хороо, Дамбадаржаагийн суурин харуулын хэмжилтийг сэргээж, улсын сүлжээнд холбосон бөгөөд хэмжилтийн ажиллагааг тогтворжуулах, тасалдлыг арилгах зорилгоор Жайка байгууллагын мэргэжилтэн Хироюүки Маедатай мэргэжилтэн Р.Болд-Эрдэнэ, оператор, техникч Б.Адъяа-очир холбогдон ажиллаж байна. ЦУОШГ-аас 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1/743 дугаар хэмжилтийн дүн ирүүлэх тухай албан хүсэлтийн дагуу Дамбадаржаагийн суурин харуул дээр 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш хэмжигдсэн бүх дүнг хүргүүлэхээр нэгтгэн ажиллаж байна.

7. Дамбадаржаагийн суурин харуулын 2021 оны өвөл шаардлагатай сэлбэг хэрэгслийг худалдан авахаар Японы "Кимото" компанитай холбогдож, 6.0 сая төгрөгийн сэлбэгийг худалдан авах гэрээ байгуулж, төлбөрийн нэхэмжлэхийг НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст шилжүүлээд байна.

8. Суурин харуулын өвлийн бэлтгэл байдал, хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангуулах хүрээнд суурин харуулын сэлбэг хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан "Интерсайнс" ХХК-тай 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр НАБТГ-2021/01 тоот гэрээ байгуулж, гэрээний үнийн дүнд 45.0 сая төгрөгийг шилжүүлж, сэлбэг хэрэгслийг солих, нөөцлөх ажлыг зохион байгуулсан.

9. Суурин харуулын хэмжилтийн баталгаажилтыг хангуулах зорилгоор тендер шалгарсан "Универсал инженеринг" ХХК-тай 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдөр 03/03 тоот гэрээ байгуулж гэрээний үнийн дүнд 29,9 сая төгрөгийг шилжүүлж стандарт хийг хүлээн авч, ЦУОШГ-тай агууламжийг шалгах ажлыг зохион байгуулсан.

Зураг12



Суурин харуулын хэмжилтийн ажилласан нийт цаг 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар МҮОНРТ-92,2%, Нисэх-73,8%, Толгойт-84,4%, Амгалан-78,2%, Баянхошуу-55,2% байна. Суурин харуулуудын нийт дундаж хэмжилтийн цаг 76,7%-ийн гүйцэтгэлтэй байна.

3.6 "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам"-ыг шинэчлэн тогтоож, сурталчлах ажлын хүрээнд:

Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 62, 2020 оны 189 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2021 оны "Агаарын чанарыг

сайжруулах бүс, түүнд мөрдөх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагыг ханган холбогдох байгууллагуудаас саналыг авч, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/322-А/780 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар батлуулсан.

2021 оны “Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам”-ыг иргэд олон нийтэд таниулахаар legalinfo.mn, ulaanbaatar.mn сайтад байршуулж, 23 мэдээллийн цахим хуудас, 11 нүүр хуудсаар дамжуулан сурталчилж ажилласан.

3.7 Сайжруулсан түлш нөөцлөх, түгээх, борлуулалтын цэгүүд бий болгож, үйл ажиллагааг жигдрүүлэх ажлын хүрээнд:

3.7.1 Сайжруулсан түлшний үйлдвэрлэл, нөөцлөлт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшний баруун болон зүүн бүсийн үйлдвэрийг 2019, 2020 онуудадад үе шаттай нээж, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 195,000 гэр хороолын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлыг эхлүүлсэн. Тус 2 үйлдвэр нь 17 шугамаар хоногт дунджаар 3200-4000 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй ажиллаж эхэлсэн. Одоогоор баруун бүсийн үйлдвэр нь хоногт дунджаар 12 шугамаар 1700-1800 тонн, зүүн бүсийн үйлдвэр нь хоногт 4 шугамаар 500-600 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж байна.



Зураг 13. Зүүн бүсийн үйлдвэр сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж буй байдал

Монгол Улсын Засгийн газрын “Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 200 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” А/1295 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 07 дугаар хуралдаанаар тус тус агаарын чанарыг сайжруулах бүсэд орших гэр хорооллын айл өрхийн хэрэглээний сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж, түлшний хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор түлш нөөцлөхөд шаардлагатай агуулах түрээслэх ажлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн 5-9 саруудад зохион байгуулж, гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт үүрэг болгосон. Энэхүү ажлын хүрээнд Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны А/15 дугаар тушаалаар өвөлжилтийн бэлтгэл хангах, түлшний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай агуулах түрээслэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 5

хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь агуулахад тавигдах ажлын даалгаварыг боловсруулан түрээслэх агуулахыг сонгохдоо “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуул”-ийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт хийх зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдөр НАБТГ-ын www.aprd.gov.mn сайтад зар тавьж материал ирүүлсэн шаардлагад нийцсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллахаар болсон.

Нийт 45 материал ирүүлснээс түлш нөөцлөх боломжтой шаардлагад нийцсэн 14 иргэн, 22 аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар агуулах түрээслэх гэрээ байгуулсан.

Хүснэгт-3

№	Дүүргүүд						Нийт
	Баянгол	Баянзүрх	Сонгино-хайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	
2021.01.01-2021.05.30	2		1			1	4
2021.06.01-2021.12.31	4	7	15	2	5	3	36
Бүгд дүн	6	7	16	2	5	4	40

/Гэрээ байгуулсан агуулахын тоо дүүргээр харуулав/

Зураг 14.



Тайлбар: Ажлын хэсгийн тушаал, ажлын даалгавар болон ажлын хэсгийн хуралдаан

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдсан 5 агуулахад **3,900**, “Таван толгой түлш” ХХК-ийн 22 саравчид **3,966**, 27 хангамжийн баазад **16,652.3**, түрээсийн 36 агуулахад **52,341**, “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн хашаанд **21,200**, 2020 оны түлшний үлдэгдэлтэй байсан он дамнаж гэрээ байгуулсан “Зуун заан” ХХК, “Онц таван толгой” ХХК, “Мон-Кара” ХХК, “Төв хүрээ” ХХК-ниудын 4 агуулахад **17,510**, 2021 оны бүтэн жилийн байдлаар нийт 6 дүүргийн хэмжээнд **115,569.3** тонн сайжруулсан түлшний нөөц бүрдүүлж, **1,297,510,961** /Нэг тэрбум хоёр зуун ерөн долоон сая таван зуун арван мянга есөн зуун жаран нэгэн/ төгрөгийн санхүүжилтийг агуулахын түрээсийн зардалд 2021.12.01-ний байдлаар олгосон.

Хүснэгт-4

Нэр	2021.1.1-2021.6.31	2021.7.1-2021.12.01	Нийт олгосон санхүүжилт
Агуулах	134,188,000	1,163,322,961	1,297,510,961

Олгосон санхүүжилт эхний болон сүүлийн хагас жилээр

Дүүрэг	2021.01.01-2021.05.30 Нөөц /тонн/	2021.06.01-2021.12.30 Нөөц /тонн/
Баянгол	8,845.3	4,157
Баянзүрх	5,845.3	12,642
Сонгинохайрхан	14,404.0	34,768
Хан-Уул	4,489.9	7330
Сүхбаатар	4,566.0	4,061
Чингэлтэй	7,643.5	6,766
Нийт	45,845.3	69,724

2021 онд нийт 115,569.3 тонн сайжруулсан түлшний бүрдүүлсэн.

Зураг 15.



2021 оны 12 дугаар сарын 06-ны байдалаар 32,263 тонн сайжруулсан түлшний нөөцтэй байна.

“Таван толгой түлш” ХХК-иас сайжруулсан шахмал түлшний нөөц, барьцалдуулагчийн нөөцийн мэдээг aprd.air@gmail.com хаягаар өдөр бүр 10 цагт хүлээн авч байна. Мөн Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн шуурхай штабын ubcity2020@gmail.com, nokshuurkhaishtab@gmail.com, doljinsurenbayarsaikhan@gmail.com, nok@ulaanbaatar.mn, stock@shtab.gov.mn цахим хаяг руу сайжруулсан түлшний өдөр тутмын борлуулалт, түгээлтийн мэдээг 09:00, 13:00, 17:00 цагуудад тогтмол байгууллагын цахим хаягаар илгээн ажиллаж байна.

3.7.2 Сайжруулсан түлшний тээвэрлэлт

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Гэрээ байгуулан ажиллах тухай” А/1296 дугаар захирамжаар сайжруулсан хатуу түлш тээвэрлэлтийн ажлын ерөнхий шаардлагыг үндэслэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт үүрэг болгосон.

Энэхүү захирамжийн хүрээнд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2021 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, түлш тээвэрлэх шаардлага хангасан 35 тээврийн компанийг сонгон шалгаруулсан.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, “Таван толгой түлш” ХХК нь шалгарсан 35 тээврийн компанитай 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаагаар “Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ”-г байгуулж, эхний хагас жилийн гэрээний гүйцэтгэлийг тээврийн компаниудаас ирүүлсэн тайланг үндэслэн гэрээг дүгнэж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 34 компанитай гэрээг сунган ажиллаж байна.

Зураг 16.



Тайлбар: Захирамж, ажлын хэсгийн тушаал болон сайжруулсан түлшний тээврийн гэрээ

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 35 тээврийн компани нь 651,397 тонн сайжруулсан түлш тээвэрлэж, тээвэрлэсэн түлшний гүйцэтгэлийн дагуу **12,544,711,599** /Арван хоёр тэрбум таван зуун дөчин дөрвөн сая долоон зуун арван нэгэн мянга таван зуун арван ёсөн/ төгрөгийн санхүүжилтийг олгож, тээвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт-6

Нэр	2021.01.01-2021.06.31	2021.07.01-2021.12.01	Нийт олгосон санхүүжилт
Тээвэр	9,188,814,328	3,355,897,271	12,544,711,599

Олгосон санхүүжилт эхний болон сүүлийн хагас жилээр

Хүснэгт-7

Сайжруулсан түлшний тээвэрлэлтийн 2021 оны гүйцэтгэл

2021.01.01- 2021.12.05-НЫ АЧИЛТЫН ТАЙЛАН			
№	ДҮҮРЭГ	НИЙТ КГ	
		Рейсын тоо	Жин /кг/
1	Баянзүрх Дүүрэг	23581	169,184,835
2	Сонгино Хайрхан Дүүрэг	35395	233,456,425
3	Хан-Уул Дүүрэг	9682	68,161,750
4	Баянгол Дүүрэг	5299	26,796,830
5	Сүхбаатар Дүүрэг	9246	59,023,690

6	Чингэлтэй Дүүрэг	14458	94,713,655
Нийт :		97,661	651,397,185

Сайжруулсан түлшний тээвэрлэлтийн 35 компани нь 773 автомашин, үндсэн жолооч 773 хүн, ээлжийн жолооч 36 хүн, ачигч 384 хүн нийт 1,193 хүн хүчний нөөцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. 2021 онд 35 тээврийн компани нь 97,661 удаагийн рейсээр 651,397 тн сайжруулсан шахмал түлш тээвэрлэсэн байна.


Зураг 17.



Хүснэгт-8

Он	Эхний хагас жилд ажилласан тээврийн компанийн тоо	Сүүлийн хагас жилд ажилласан тээврийн компанийн тоо	Тээвэрлэсэн түлшний хэмжээ /тонн/
2019	-	11	215,844
2020	11	22	426,945
2021	35	34	651,397

Нийслэлийн 6 дүүрэгт тээвэрлэсэн түлш /тн/



Тайлант хугацаанд “Таван толгой түлш” ХХК-ийн баруун зүүн үйлдвэр, 5 хангамж бааз, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдсан 5 агуулах, түрээсийн 36 агуулахаас нийлүүлэгдэж байгаа сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт, захиалгын дагуух түгээлтэд тус байгууллагын 13 диспетчер хяналт тавьж ажилласан. Сайжруулсан түлш

тээвэрлэх гэрээний гүйцэтгэл дүгнэсэн актыг сар бүр “Таван толгой түлш” ХХК-иас ирүүлэн түлшний тээвэрлэлтийн мэдээтэй тулган хянан баталгаажуулан ажилласан.

Диспетчерүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар тогтмол хангаж, сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлтийн мэдээг өдөр бүрээр авч, сар бүрийн тайланг нэгтгэн, удирдлагуудад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна.

3.7.3 Сайжруулсан түлшний борлуулалт

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны “Сайжруулсан шахмал түлшний борлуулалтад уамшуулал олгох” тухай 19/12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Борлуулалтын урамшуулал олгох тухай” А/967 дугаар захирамжийн хүрээнд сайжруулсан түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар болон “Таван толгой түлш” ХХК нар хамтран 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийг хүртэл, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тус тус “Сайжруулсан шахмал түлшний борлуулалтад урамшуулал олгох тухай” санхүүжилт олгох гэрээг байгуулсан. 2021 оны эхний хагас жилд агаарын чанарыг сайжруулах бүсэд 686 борлуулалтын цэг, сүүлийн хагас жилд 600 борлуулалтын цэгийг “Таван толгой түлш” ХХК нь сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүснэгт-9

Дүүрэг	БЦ-ийн тоо 2021.01.01- 2021.05.30	БЦ-ийн тоо 2021.10.01	БЦ-ийн тоо 2021.10.06	БЦ-ийн тоо 2021.11.01	БЦ-ийн тоо 2021.11.30
БГД	40	12	20	24	32
БЗД	170	64	115	138	160
СХД	228	130	141	175	210
ХУД	59	20	33	47	52
СБД	74	22	37	43	56
ЧД	90	36	71	85	90
Нийт	686	284	417	512	600

2021 онд нээж ажиллуулсан сайжруулсан түлшний борлуулалтын цэгийн тоо

Нийслэлийн гэр хорооллын 99 хорооны гэр хорооллын 195,992 айл өрхийн хоногийн дундаж хэрэглээнд 2400-3500 тонн сайжруулсан түлшийг 600 борлуулалтын цэгээр борлуулж байна.

2021 онд гэр хорооллын айл өрх нь дунджаар **421,552.25** тонн сайжруулсан шахмал түлш хэрэглэсэн ба үүний борлуулалтын урамшуулал болох **6,323,283,675.61** /Зургаан тэрбум гурван зуун хорин гурван сая хоёр зуун наян гурван мянга зургаан зуун далан таван төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгийг “Таван толгой түлш” ХХК-иас ирүүлсэн гүйцэтгэлийн дагуу нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраас олгосон.

Нэр	2021.01.01-2021.06.31	2021.07.01-2021.12.01	Нийт олгосон санхүүжилт
БЦУ	5,210,250,00	1,113,033,675	6,323,283,675

(Олгосон санхүүжилт эхний болон сүүлийн хагас жилээр)

Зураг 18.



Нийслэлийн 6 дүүргийн 600 борлуулалтын цэгт “Таван толгой түлш” ХХК, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, бусад харъяа байгууллагуудтай хамтран сайжруулсан түлшний татан авалт, нөөцлөлтөд хяналт тавин, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, сайжруулсан түлштэй холбоотой гомдол саналыг шийдвэрлэн ажиллаж байна.

3.7.4 Өндөрлөг цэгүүдэд оршин суудаг иргэдийг сайжруулсан түлшээр хангах ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сайжруулсан түлшний цэгийг нэмж байгуулах тухай” А/1273 дугаар захирамжийн хүрээнд сайжруулсан шахмал түлшний хүрэлцээг хангах зорилгоор 2021 онд Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөөгөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулан агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах өндөрлөг цэгүүдэд оршин суудаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон 26,630 иргэдийн судалгааг дүүргүүдээс авч нэгтгэсэн.



Зураг 12. Захирамж, ажлын хэсгийн тушаал зургаар харуулав

Өндөрлөг цэгт нэмэлтээр 67 борлуулалтын цэг байгуулах ажлыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар болон “Таван толгой түлш” ХХК нар хамтран дээрх цэг байгуулах боломжтой байршлуудад нэг бүрчлэн очиж нөхцөл байдлыг тодорхойлон ажилласан.

Зураг 19.



Зураг 13. Өндөрлөг цэгүүдийн байршил

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өндөрлөг цэгүүдэд сайжруулсан түлшний борлуулалтын цэгийг нэмж байгуулснаар тухайн өндөрлөг цэгүүдэд оршин суудаг зорилтот бүлгийн 26,630 иргэд өөрийн гэр болон сууцандаа илүү ойр боломжтой байршлуудаас сайжруулсан түлшээ авах боломжийг бүрдүүлэн ажилласан. Эдгээр цэгүүдэд түлшийг тээвэрлэн хүргэх зорилгоор туулах чадвар сайтай автомашинтай тээвэрлэлтийн “Тас хүлэг” ХХК, “Өгөөдэй богд транс” ХХК, “Эвт хангай экологи” ХХК, “Арвижих глобал транс” ХХК, “Буянт хүлэг” ХХК-иудыг зохих хууль, журамд нийцүүлэн сонгон шалгаруулж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд НЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, “Таван толгой түлш” ХХК нар хамтран сайжруулсан түлшийг өндөрлөг цэгт хүргэх ажлын гэрээг байгуулан хяналт тавин ажилласан.

2021 оны эхний хагас жилд дээрх 4 компани нь 64 цэгт 3301 удаагийн рейсээр 28,312 тонн сайжруулсан түлшийг тээвэрлэн хүргээд байна.

Хүснэгт-11

2021.01.01-2021.05.31 ХООРОНД ТҮЛШ ТЭЭВЭРЛЭСЭН БАЙДАЛ		
Д/д	ААНБ-ын нэр	Тээвэрлэсэн түлшний хэмжээ тонн
1	“Тас хүлэг” ХХК	2,844
2	“Өгөөдэй богд транс” ХХК	5,466
3	Эвт хангай экологи” ХХК	6,940
4	“Арвижих глобал транс” ХХК	3,582
5	“Буянт хүлэг транс” ХХК	9,480
Нийт		28,312



Зураг 20. Сайжруулсан түлшний тээвэрлэлтийн байдал

3.7.5 Зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах ажил

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, 2020 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 189 дүгээр тогтоол, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/20 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Зорилтот өрхийг сайжруулсан түлшээр хангах тухай” А/30 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангах ажлыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар болон “Таван толгой түлш” ХХК хамтран 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн 6786 өрхөд 925 кг-аар савласан нийт 6277 тн түлшийг олгосон.

Хүснэгт-12

№	Дүүрэг	Олгосон өрхийн тоо	1 өрхөд олгох түлшний хэмжээ /кг/	Нийт олгосон түлшний хэмжээ /кг/
1	Баянгол	275	925	254,375
2	Баянзүрх	1326	925	1,226,550
3	Сонгинохайрхан	2543	925	2,352,275
4	Хан-Уул	672	925	621,600
5	Чингэлтэй	1338	925	1,237,650
6	Сүхбаатар	632	925	584,600
Нийт		6786	-	6,277,050



Зураг 21. Зорилтот өрхөд сайжруулсан түлш олгож буй байдал

4. Халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх ажлын хүрээнд :

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Эрх шилжүүлэх, хөрөнгө гаргах тухай” А/639 дүгээр тушаалаар баталгаажуулан захиран зарцуулах эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар:

- Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41 дүгээр сургууль, 29, 71 дүгээр цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох;
- Баянзүрх дүүргийн 8, 16, 19 дүгээр хороо Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох;
- Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан, хүйтэн ус хангамжид холбох;
- 4.Хан-Уул дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 дугаар сургууль, 209, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох дулаан дамжуулах төвийн нийт 4 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжүүлсэн.
- Хан-Уул дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 дугаар сургууль, 209, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох дулаан дамжуулах төвийн нийт 4 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжүүлсэн.

Эдгээр төсөл арга хэмжээнүүдийг Худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дээрх 4 байршлын 36 халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Нийт барилга угсралтын ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

5. Агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажил зохион байгуулах ажлын хүрээнд:

Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/479 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1285 дугаар захирамжийг тус тус үндэслэн 2020 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг 2021 оны 01 дугаар сарын 20-ны өдрөөс Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөөгийн баталсан удирдамжийн дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. Энэ удаагийн бүртгэл тооллогын ажил ОББҮХ-ны цахим бүртгэлийн шинэ системд бүртгэж байгаатай холбогдуулан тооллого явуулах талаар сургалтыг 2021

оны 01 сарын 22-ны цахимаар зохион байгуулж 9 дүүргийн мэргэжилтэн болон хороодын албан хаагчид, нийт 100 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 9 дүүргийн хэмжээнд явуулж дуусган тоо бүртгэлийн мэдээ, тайланг Цаг, уур орчны шинжилгээний газарт хүргүүлсэн.

2021 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11-р сарын 29-ний өдрийн А/930 дугаар захирамжаар батлуулсан. Энэ ажлын хүрээнд 2021 оны 11-р сарын 30-ны өдөр нийслэлийн 6 дүүргийн агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлыг хийх талаар зааварчилгаа өгсөн. Тооллогын ажил эхлээд байна.

6. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрүүд:

6.1 Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуух: Үүнд: айл өрхийн ахуйн хэрэглээ, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж байгаа уламжлалт болон сайжруулсан зуух, пийшин, усан халаалтын зуух хамаарна. Тооллогын мэдээг дүүрэг тус бүрээр харуулбал:

Хүснэгт-13

Нийслэлийн 9-н дүүргээр	Нийт зуухны тоо	Гэрийн зуухны тоо		Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ				Байшингийн зуухны тоо		Байшингийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ			
		ердийн	сайжруулсан	Нүүрс,тн	Мод,тн	сайжруулсан түлш	Бусад	ердийн	сайжруулсан	Нүүрс,тн	Мод,тн	Сайжруулсан түлш	Бусад
БЗД	26666	8471	6701	0	24760.5	37980.5	29.5	7194	4300	120	22102	32282.9	1612
БГД	7647	3654	1383	220	1385	26545	129	1451	1159	112	1712	14077	97
БНД	3613	1767	383	11703	7974	0	943	1098	365	8777	5882	0	20
БХД	331	164	19	915	36	0	549	145	3	1184	29.8	0	426
НД	7226	3781	536	19402.3	5711	122	128.4	2491	418	21137.9	9936	352	85
СХД	52748	15790	9143	0	37399.5	89759	98	16077	11738	0	41722.5	100134	16
СБД	11205	2614	2128	0	7113	17782.5	0	3418	3045	0	9694.5	24236.25	0
ХУД	11930	3129	2068	2907	6892.5	14830	289.84	4332	2401	2048	14005	28310.9	629
ЧД	20602	3900	3167	0	12249.5	18222.7	81	8173	5362	0	24690	43293.5	136
Нийт	141968	43270	25528	35147.3	66121.5	205242	2247.74	44379	28791	33378.9	88051	242686.55	3021

2019 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын дүнтэй харьцуулбал

Хүснэгт-14

Нийслэлийн 9-н дүүргээр	Нийт зуухны тоо	Гэрийн зуухны тоо		Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ				Байшингийн зуухны тоо		Байшингийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ			
		ердийн	сайжруулсан	Нүүрс,тн	Мод,тн	сайжруулсан түлш	Бусад	ердийн	сайжруулсан	Нүүрс,тн	Мод,тн	Сайжруулсан түлш	Бусад
2019	170807	40007	38633	135901	0	96582	12642	49827	42340	180735	0	117362	16470
2020	141968	43270	25528	35147.3	66121.5	205242	2247.74	44379	28791	33378.9	88051	242687	3021

2019 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын 3-15 квт хүчин чадалтай 170807 зуух тоологдсон. Түүхий нүүрс 316636 тн байсан.

2020 онд “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай” удирдамжийн дагуу 3-15 квт, зуухнуудын тооллогыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын

газартай хамтран зохион байгуулсан. Тооллогод нийслэлийн 9 дүүргийн 141968 зуух хамрагдсан ба 3-15квт хүчин чадалтай гэр хорооллын айл өрхийн яндангийн тоо 28839 - ээр, түүхий нүүрсний хэрэглээ 248110 тн-оор буурсан байна.

6.2 Усан халаалтын 15-100 кВт, 101-4200 кВт хүртэл хүчин чадалтай зуух:

15-100кВт, 100-4200кВт хүчин чадалтай халаалтын зуухуудад бүртгэл тооллого явуулах, мэдээллийн санг шинэчлэх ажлын гүйцэтгэгчээр “Таканар” ХХК-ийг сонгож, гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн.

Усан халаалтын 15-100 кВт хүртэл хүчин чадалтай зуух нийт 2810 тоологдсон ба 2019 онд 74899 тн түүхий нүүрс, 45943 тн сайжруулсан түлш, 2020 онд зуух нийт 2681 тоологдсон 43259.74 тн сайжруулсан түлш түлсэн байна.

Хүснэгт-15

Дүүрэг	15-100квт хүртэл хүчин чадалтай зуух		
	Зуухны тоо	Жилд хэрэглэсэн түлшний хэмжээ	
		Нүүрс, тн	Сайжруулсан түлш, тн
2019	2810	74899	45943
2020	2681		43259.74

6.3 Усан халаалтын 101-4200 кВт хүртэл хүчин чадалтай зуух. Үүнд: технологийн зориулалттай зуух, төвлөрсөн болон нэгдсэн дулаан хангамжийн системийн усан халаалтын зуух, барилгын болон томоохон үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа зуух;

Хүснэгт-16

№	ААНБ	100квт-аас дээш хүртэл хүчин чадалтай халаалтын зуух	
		Зуухны тоо	Жилд хэрэглэсэн түлшний хэмжээ
			Нүүрс, тн
1	239	343	66357
2	260	463	216212.5

2020 оны уурын болон усан халаалтын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай зуух

Хүснэгт-17

№		Зуухны тоо	Жилийн нүүрсний хэмжээ жилд /тн/
1	ТЭЦ-2	5	227400
2	ТЭЦ-3	13	1340600
3	ТЭЦ-4	8	3583100
4	Амгалан ДС	3	250200
5	Налайх ДС	3	36700
6	Багануур ДС	9	64800
НИЙТ		41	5502800

2020 онд “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай” удирдамжын дагуу 3-15 кВт, 16-100 кВт, 100 кВт-аас дээш хүчин чадалтай бүх төрлийн

халаалтын зуухнуудын тооллогыг нийслэлийн 9 дүүргийн 3-15 кВт хүчин чадалтай 141968 зуух, 16-100 кВт хүчин чадалтай 2681 зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 463 зуух хамрагдсан ба 3-15квт хүчин чадалтай гэр хорооллын айл өрхийн яндангийн тоо 28839-оор буурч, 16-100 кВт хүчин чадалтай 129 зуухаар буурч, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 120-оор нэмэгдсэн байна.

2019 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын дүнтэй харьцуулбал:

График 1.



6.4 Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр:

Нийслэлийн агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөөгөөр 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр батлуулсан 2021/03 тоот “Автотээврийн хэрэгслийн яндангаас гарах дуу чимээ, ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх хяналт, хэмжилтийн ажлыг Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, БГД-ийн ЗДТГазар, Тээврийн цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ хамтран 2021 оны 09 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны Буянт-Ухаа тойрог зам, Чингэлтэй дүүргийн 19 хорооны Зуслангийн замд автотээврийн хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтэнд нийт 52 тээврийн хэрэгсэл хамрагдснаас **36** дизель тээврийн хэрэгслээс **35** буюу **97%-** нь тортогжилтын байдал стандартын шаардлагад нийцээгүй байсан бол 17 бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээс **7.3%-**нь стандарт хангаагүй гэсэн дүнтэй гарсан байна.

АТҮТ-ийн инженерүүд тухайн тээврийн хэрэгсэлд зөвлөгөө өгч, техникийн үзлэгт дахин орох, автомашинд засвар үйлчилгээ хийлгэх заавар өгч ажилласан.

Хүснэгт 18

Зориулалт*										
Он	нийт автотээврийн	суудал	нийтийн тээвэр /автобус/	ачаа	тусгай зориулалт	цистерн	зүтгүүр	механизм	чиргүүл	мотоцикл
2019	578027	423918	11795	79120	7516	2522	13649	10273	23451	5783
2020	621939	452332	16492	83073	7211	2645	16724	11076	22519	9867

7. Гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний үнийг хөнгөлөх ажлын хүрээнд :

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн 481 дүгээр тогтоолын дагуу 2020 оны 11 дүгээр 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 100 хувиар хөнгөлөх тухай батлагдан хэрэгжиж эхэлсэн. Энэхүү тогтоолын дагуу 2021 оны 10 дугаар сарын байдлаар нийт 121,379 хэрэглэгчид 13.3 тэрбум төгрөгийн тарифын хөнгөлөлт үзүүлээд байна.

8. "Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг халаалтаа дэвшилтэт технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуураар шийдэх боломжийг бүрдүүлэх" ажлын хүрээнд:

УБЦАТ-ийн хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд нийслэлийн 5 дүүргийн 41 хорооны гэр хороололд 4квт цахилгаан хангамжийн боломж бүрдсэн 340 айл өрхөд "шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурыг суурилуулах" хөтөлбөрийг "Дулаалга аян" 5-тай хослуулан хэрэгжүүлсэн.

9. "Гэр хорооллын байшин, сууцны дулааны алдагдлыг бууруулах" ажлын хүрээнд:

УБЦАТ-ийн хүрээнд айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулах "Дулаалга аян"-д нийт 223 айл өрх хамрагдаж байгаа бөгөөд үүнээс 82 байшин/гэр-ийг 70 хувийн татаастайгаар бүрэн дулаалсан байна. 2020-2021 онуудад нийт 1807 айл өрхөд хэмжилт хийсэн.

10. Автотээврийн хэрэгслээс гаралтай бохирдлыг бууруулах талаар

Нийслэлийн агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөөгөөр 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр батлуулсан 2021/03 тоот "Автотээврийн хэрэгслийн яндангаас гарах дуу чимээ, ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх хяналт, хэмжилтийн ажлыг Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, БГД-ийн ЗДТГазар, Тээврийн цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ хамтран 2021 оны 09 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны Буянт-Ухаа тойрог зам, Чингэлтэй дүүргийн 19 хорооны Зуслангийн замд автотээврийн хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтэнд нийт 52 тээврийн хэрэгсэл хамрагдснаас **36** дизель тээврийн хэрэгслээс **35** буюу **97%**- нь тортогжилтын байдал стандартын шаардлагад нийцээгүй байсан бол 17 бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээс **7.3%** нь стандарт хангаагүй гэсэн дүнтэй гарсан байна.

АТҮТ-ийн инженерүүд тухайн тээврийн хэрэгсэлд зөвлөгөө өгч, техникийн үзлэгт дахин орох, автомашинд засвар үйлчилгээ хийлгэх заавар өгч ажилласан.




Нисэхийн тойрог Зураг-1



Нисэхийн тойрог Зураг-2



Хайлааст чиглэл Зураг-2






Зуслангийн чиглэл Зураг-3

11. Эх үүсвэрийн ялгарлын инвенторыг шинэчлэх ажлын хүрээнд:

Агаарын бохирдуулагч эх үүсвэрүүдийн ялгарлын инвентор боловсруулах ажлын хүрээнд 2017 оны тайланг бүрэн гаргаж, архивын материалд хүрээлгэн өгсөн. Мөн 2018 оны эх үүсвэрийн ялгарлын инвенторын тайланг 2021 оны 10 сард нөхөн боловсруулж дууссан ба тус тайланг байгууллагын албан ёсны цахим хуудсанд <http://www.aprd.ub.gov.mn/k?mID=1035> байршуулсан.

2018 оны эх үүсвэрийн ялгарлын тооцооллын дүнгээр бохирдуулагч бодисын хэмжээ буюу хүхэрлэг хий (SO₂) 16 972 тн/жил, том ширхэглэгт тоосонцор (PM₁₀) 32 343 тн/жил, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) 62 768 тн/жил байгааг 2017 онтой харьцуулбал SO 1,2%-иар бага, PM₁₀ 0,01%-иар их CO 14,3%-иар тус тус бага гарсан үзүүлэлттэй байлаа.



Тус тайланг Жайка төслийн мэргэжилтэн Шиняа Накатагаас цахимаар заавар зөвлөгөө авч боловсруулж дууссан. 2018 оны эх үүсвэрийн ялгарлын инвентороос гарсан үр дүнгээр

гэрийн зуухны тархалтын загварчлалын зургийг ArcGIS 10.4.1 програм ашиглан боловсруулсан.

2020 оны агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн бүртгэл тооллогод хамрагдсан 3-15кВт, 16-100кВт, 100кВт-с дээш зуухны мэдээлэл, Дулааны цахилгаан станцын нүүрсний зарцуулалт, автотээврийн бүртгэлд хамрагдсан тээврийн хэрэгслийн мэдээлэл зэргийг Жайка төслийн мэргэжилтэн Наката Шиняэд цахимаар явуулан тоон мэдээлэл боловсруулахад хамтран ажиллаж байна. 11 сарын байдлаар 3-15кВт гэрийн зуух, Дулааны цахилгаан станц, 15-100кВт зуухны эх үүсвэрийн ялгарлын тооцооллыг гаргасан.

12. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулах ажлыг хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/346 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 2021 оны 1-р сарын 20-ны өдрөөс 6-р сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хог тээвэрлэгч аж ахуйн нэгжийн машин механизмаар сэрэмжлүүлэх зөвлөмжийг дуут дохиогоор өгөх, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн ажиллагааны зааварчилгаа, зуух пийшингийн битүүмжийг шалгах, агааржуулалтыг тогтмол хийхийг сурталчилсан 260000 ширхэг гарын авлага, зөвлөмж, 7 төрлийн постер, 3 төрлийн видео бэлтгэн 22 веб хуудас, 2 телевизээр иргэдэд мэдээлэл хүргэн, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.



Зураг 23. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч буй байдал



Зураг 24. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зурагт хуудас байршуулсан байдал

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлье” аяныг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Аяны хүрээнд:

- MGL радио 88.3, 91,1 FM радиогоор угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 5 төрлийн зөвлөмжийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.
- Угаарын хийн эрсдэлээс сэргийлэх 4 төрлийн мессэжийг үүрэн телефоны операторуудаар дамжуулан хүргэсэн.
- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 10 цуврал постер бэлтгэж байгууллагын албан ёсны вэбсайт <http://www.aprd.ub.gov.mn/>, Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, <https://ulaanbaatar.mn/> Нийслэлийн мэдээ фэйсбүүкийн цахим хуудас, хашаандаа сайхан амьдаръя цахим групп, хамтран ажилладаг 4 сайтаар дамжуулан давхардсан тоогоор нийт 50,000 гаруй хүнд хүргэж ажилласан.
- Гэр хорооллын сургуулиудын мэдээллийн самбарт 6 төрлийн 600 ширхэг угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас байршуулсан.
- Угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий стикер, хулдаасан хэвлэлийг автобусны буудал, зам дагуу байрлах самбарт байршуулан иргэд, олон нийтэд хүргэсэн.
- Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, зорилтот бүлгийн 10,000 айл өрхийн янданг хөөлөх зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

Зураг 25.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн “Угаарын хий мэдрэгч төхөөрөмж нэмэлтээр олгох тухай” А/1066 дугаар захирамжийн дагуу үлдэгдэл 46 ширхэг, эвдрэл гэмтэлтэй 199 ширхэг угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг засварлаж, зорилтот бүлгийн айл өрхүүдэд суурилуулж өгөх зорилгоор Таван толгой түлш” ХХК-ийн “Хэрэглэгчид үйлчлэх алба”-д 2021 оны 11-р сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Зураг 26.



13. Хяналт-шалгалт, судалгааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тухай

13.1 100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд магадлан итгэмжлэл явуулах, 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухнаас ялгарах үнс, тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд:

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй усан халаалтын зуух, 100 кВт-аас дээш нэгж хүчин чадалтай зуухны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлыг зохион байгуулах удирдамжийг Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчаар батлуулж, холбогдох байгууллагуудад 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/438 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. Тус ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухнуудад магадлан итгэмжлэх ажил 100% хийгдсэн. Тооллогоор 29 ААНБ-ын 54 зуух тоологдож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Зураг 27.



100кВт-аас дээш хүчин чадалтай усан болон уурын халаалтын зуух эзэмшигч 9 аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зууханд хаягдал утааны хэмжилт хийж, хэмжилтийн орлого 1,5 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэв.



Зураг 28 Хаягдал утааны хэмжилт хийж буй байдал

14. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл үйлчилгээнд агаарын чанарын хяналт, хэмжилт хийнэ.

1. Улаанбаатар хотод ажиллаж байгаа барилгын материалын үйлдвэрлэл, олборолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа аж ахуйн үйл ажиллагаанд агаарын чанарын хэмжилт, судалгаа хийх ажилд төрийн холбогдох байгууллагуудын оролцоог хангаж, харилцан мэдээлэл, туршлага солилцох зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан. Энэ ажлыг хэрэгжүүлэх удирдамжийн төслийг боловсруулан хамтран ажиллах тухай албан бичгийг 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 1/222 дугаар албан бичгээр Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлсэн. Хэмжилтийг 2021 оны 07 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 01 хүртлэх хугацаанд багтаан зохион байгуулсан.

2. Улаанбаатар хотод бетон зуурмагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын орчины 12 цэгт, “ДЦС-3” ТӨХК-ийн орчимд гэсэн байршлуудад газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд орчны агаарын чанарын хэмжилт хийсэн.

Хэмжилтэнд баримталсан стандарт “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016.

Зураг 29



Авто зам дагуу хэмжилт хийж буй байдал

14.2. Байгууллага аж ахуйн нэгж, иргэний орчны хэмжилт хийлгэх хүсэлтийн дагуу БЗД-ийн 21-р хороонд үйл ажиллагаа явуулж байгаа ШШГЕГ-ын харъяа “Төр хур” амралт, сувилалын газар, БЗД-ийн 20-р хороо, Шар хоолойд үйл ажиллагаа явуулж байгаа “Далд засал” эмчилгээ сувилалын газруудад орчны агаарын чанарын хэмжилтийг хийж, нийслэлийн төсөвт 186,000 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөв төвлөрүүлсэн.

ШШГЕГ-ын харъяа “Төр хур” амралт, сувилалын газрын хэмжилтийн дүн

Хүснэгт 19

Үзүүлэлт	PM10 мкг/м ³	PM2,5 мкг/м ³	TSP мкг/м ³		
2-р цэг Сувилалын орчин	23	19	26	24	22
Тайлбар: PM2.5 – жижиг ширхэглэгт тоосонцор, PM10 – том ширхэглэгт тоосонцор TSP-нийт тоосонцор	100	50	500		
	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 20 минутын дундаж стандарт		

“Далд засал” ХХК-ийн сувилалын газрын хэмжилтийн дүн

Хүснэгт 20

Үзүүлэлт	PM10 мкг/м ³	PM2,5 мкг/м ³	TSP мкг/м ³	
1-р цэг Суурьшлын бүс	220	212	272	187
2-р цэг Сувилалын орчин	170	164	204	199
Тайлбар: PM2.5 – жижиг ширхэглэгт тоосонцор, PM10 – том ширхэглэгт тоосонцор TSP-нийт тоосонцор	100	50	500	
	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 20 минутын дундаж стандарт	

Хэмжилтийн үр дүн: Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраас 2021 оны 11 дүгээр сарын 10-12-ны өдрүүдийн хооронд СХД-ийн 20 дугаар хороо, ХУД-ийн 21 дүгээр хороо, БЗД-ийн 11 дүгээр хороонд үйл ажиллагаа эрхлэж байгаа барилгын бетон зуурмагийн түүхий эд үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байгууллагын ашиглаж буй нийтийн эзэмшлийн авто замын дагуу орчны агаарын чанарын хэмжилт хийхэд түүхий эд тээвэрлэх явцад хаягдсан цемент болон авто замын элэгдлээс агаарт дэгдэх тоосжилтын хэмжээ орчны **АЧХХ-ээс PM2,5** тоосонцор **2-35 дахин**, **PM10** тоосонцор **1-33 дахин их** гэж тус тус хэмжигдсэн.


СХД, ХУД-ийн эдгээр 10 цэгт хийсэн хэмжилтийн байршил нь Улаанбаатар хотын салхины зонхилох зүгт буюу баруун болон баруун хойд талд /салхины дээд тал/ байрлалтай бөгөөд агаарт дэгдсэн тоосжилт нь Улаанбаатар хотын ХУД, СХД-гийн нутаг дэвсгэрт бууж, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэр байдлыг алдагдуулж, суурьшлын бүсэд оршин суугч нийт иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх түвшинд хүрсэн байна.

Дүгнэлт: Иймд СХД-ийн 20 дугаар болон ХУД-ийн 21 дүгээр хороодод үйл ажиллагаа эрхлэж байгаа бетон зуурмагийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас үүсэж байгаа тоосжилтыг бууруулах арга хэмжээг холбогдох төрийн байгууллагууд анхаарч, шийдвэрлэх талаар төсөв, төлөвлөгөөнд тусгаж, хамтран ажиллах шаардлагатай байна.

Хэмжилтийн үр дүнг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1/522 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3. ХУД-ын 3-р хороонд байрлах “ДЦС-3” ТӨХК-ийн хэмжилт: Хэмжилтийг Герман улсад үйлдвэрлэсэн Dustrack 8533 маркийн PM1, PM2.5, PM10, TSP тоосонцор тодорхойлох хүчин чадалтай автомат багажаар хийж гүйцэтгэсэн.

1-р цэг: “ДЦС-3” ТӨХК-ийн утааны эсрэг чиглэлд буюу хаягдал утааны нөлөөлөлгүй байршил /Чингисийн өргөн чөлөө станцаас 447м-ын зайтай/



2-р цэг: “ДЦС-3” ТӨХК-ийн утааны чиглэлийн дагуу хаягдал утаа буух байршилд тус тус хийлээ. /Сутай хотхон ДЦС-3-аас 995 м-ийн зайд байрладаг/

Зураг 15



Цаг агаарын байдал: Гадна орчны хэм +5, салхины хурд 2м/с, салхины чиглэл баруун өмнөөс зүүн хойд чиглэлтэй.

1-р цэг дээр PM10 тоосонцрын хэмжээ 50 мкг/м³, PM2,5 тоосонцрын хэмжээ 40мкг/м³

График 4





График 5



2-р цэг дээр PM10 тоосонцрын хэмжээ 81 мкг/м³, PM2,5 тоосонцрын хэмжээ 64,8мкг/м³

График 6





График 7



Утаатай хаягдах тоосонцрын байдал зураг дээр маш тодорхой харагдаж байна.

Хэмжилтийн үр дүн: ДЦС-д 9 зуух ажиллаж байгаа бөгөөд тус бүр усан скруббер шүүлтүүртэй. /Станцын ээлжийн инженер Б.Санчираас авсан мэдээ/

Усан скрубберийн утаа шүүх чадамж АҮК-81-90% /Жайка төслийн 2015 оны эцсийн тайлан ДЦС-3 хийсэн хэмжилтийн дүн/

Хэмжилтийг автомат багажаар хийхээс гадна утааны байдалд нүдэн ажиглалт хийсэн.

2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр цаг агаарын байдал дулаан инверсгүй, яндангийн ашиглалтын өндөр сайн байсан тул хийн төлөвтэй бохирдуулах бодис, жинлэгдэх бодис /тоосонцор/ энгийн нүдэн ажиглалтаар маш тодорхой ялгагдан харагдах боломжтой байсан.

Яндангийн ашиглалтын өндөр буюу effective height (he) гэдэг нь яндангаас ялгарах хий нь өөрт хадгалагдах дулаан болон яндангаас баагиж гарах хурднаас хамаарах хөдөлгөөний эрчмээр тодорхой өндөрт хүрч дээшилсэн тухайн өндрийг хэлдэг. Энэ өндөрт хүрсэний дараа салхиар агаарт тархаж эхэлдэг бөгөөд энэ үед хийн төлөвтэй болон жинлэгдэх бодисын ялгахад маш хялбар.

ДЦС-3-ын яндангаар хаягдаж байсан утааны хийн төлөвтэй бохирдуулагч бодисууд нь агаарт салхиар туугдаж алслагдаж байсан бол жин дарах хүнд хэсэг буюу тоосонцор хөрсөн дээр утааны чиглэлийн дагуу **800м-1км** орчимд тархаж байсан. /Сутай буянт хотхоны орчимд/

Утаа буух цэг орчимд /995 м-ийн зайд/ буюу 2-р цэгт хэмжилт хийхэд PM10 тоосонцрын хэмжээ **81мкг/м³** 1-р цэгт хэмжигдсэн PM10 тоосонцроос **37,5%-өндөр**, PM2,5 тоосонцрын хэмжээ **64мкг/м³** хэмжээ байсан бөгөөд 1-р цэгт хэмжигдсэн PM2,5 тоосонцроос **38%-иар** тус тус их байсан.

Хүснэгт 21

Хэмжилтийн цэг	Хэмжсэн үзүүлэлт	
	PM2,5 мкг/м ³	PM10 мкг/м ³
1-р цэг: ДЦС-3-ын утааны нөлөөлөлгүй байршил	40	50
2-р цэг: ДЦС-3-ын утааны чиглэлийн дагуу утаа буух цэг	64	81
ХАРЬЦУУЛАЛТ: 1-р цэгээс 2-р цэгийн агууламж:	38%-иар их	37,5%-иар их

Нүдэн ажиглалт болон **995** метрийн зайнд автомат багажаар хийсэн хэмжилтийн дүнгээр ДЦС-3-ын яндангаас хаягдах утааны чиглэлийн дагуу тоосонцор суурьшлын бүсэд хаягдаж байгаа нь хэмжилтээр тодорхойлогдсон.

Хэмжилтийн үр дүнг шүүлтүүрийн ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1/518 дугаар албан тоотыг ОББҮХ-нд хүргүүлсэн.

4. Байгууллага аж ахуйн нэгж, иргэний орчны хэмжилт хийлгэх хүсэлтийн дагуу БЗД-ийн 21 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж байгаа ШШГЕГ-ын харъяа “Төр хур” амралт, сувилалын газар, БЗД-ийн 20 дугаар хороо, Шар хоолойд үйл ажиллагаа явуулж байгаа “Далд засал” эмчилгээ сувилалын газруудад орчны агаарын чанарын хэмжилтийг хийж, нийслэлийн төсөвт 186,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Хүснэгт 22. ШШГЕГ-ын харъяа “Төр хур” амралт, сувилалын газрын хэмжилтийн дүн

Үзүүлэлт	PM10 мкг/м ³	PM2,5 мкг/м ³	TSP мкг/м ³		
			26	24	22
2-р цэг Сувилалын орчин	23	19	26	24	22
	100	50	500		
Тайлбар: PM2.5 – жижиг ширхэглэгт тоосонцор, PM10 – том ширхэглэгт тоосонцор TSP-нийт тоосонцор	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 20 минутын дундаж стандарт		

Хүснэгт-23. “Далд засал” ХХК-ийн сувилалын газрын хэмжилтийн дүн

Үзүүлэлт	PM10 мкг/м ³	PM2,5 мкг/м ³	TSP мкг/м ³	
			272	187
1-р цэг Суурьшлын бүс	220	212	272	187
2-р цэг Сувилалын орчин	170	164	204	199
	100	50	500	
Тайлбар: PM2.5 – жижиг ширхэглэгт тоосонцор, PM10 – том ширхэглэгт тоосонцор TSP-нийт тоосонцор	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 24 цагийн дундаж стандарт	MNS 4585:2016 20 минутын дундаж стандарт	

6. БЗД-ийн 26-р хорооны “Их Монгол” хорооллын оршин суугчдаас төмөр зам, авто замын гарцнаас үүсэх дуу чимээ оршин суугчдын тав тухтай амьдрах нөхцлийг алдагдуулж байна гэсэн гомдлын дагуу тус хорооллын орчинд 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр 24 цагийн хугацаатай дуу чимээний хэмжилтийг хийсэн.

Хэмжилтээр “Нарантуул” ОУХТ-ийн урагш нэвтрэх уулзварын төмөр замын саадны дуу чимээ, вагон өнгөрөх үед өгдөг дохионы дуу чимээ, дуу чимээний стандартаас тогтмол давж байгаа хэмжилтээр тодорхойлогдсон.

Хүснэгт-24

Хэмжилтийн төрөл	LAeq		LAE		LAFmax		LCpk	
	дБА		дБА		дБА		дБА	
Хэмжилтийн нэгж								
Хэмжигдсэн үзүүлэлт	74	73	86	88	90	87	112	106
MNS4585:2016 Орчны агаарын чанар техникийн ерөнхий шаардлага	45	60	45	60	45	60	45	60
Хугацаа	өдөр	орой	өдөр	орой	өдөр	орой	өдөр	орой

15. Нийслэлийн гэр хорооллын айлуудад худалдан борлуулж байгаа сайжруулсан хатуу түлшинд 14 хоног бүр хэмжилт хийж, MNS5216:2016 стандартын шаардлага хангасан эсэхэд улирал бүр тайлан гаргана.

Засгийн Газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолтой холбоотойгоор иргэн, аж ахуйн, нэгж байгууллагад түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон.

Иймд сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн стандартын шаардлага хангаж буй эсэхэд хаягдал утааны хийн хэмжилт хийсэн.

Үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 45 дээжид хаягдал утааны хэмжилт хийж дүнг боловсруулж, Монгол Улсын MNS 5216:2016 стандартыг баримтлан заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан холбогдох албан байгууллага ААНБ-д хүргүүлсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагын түлшинд хаягдал утааны хэмжилт хийж, хэмжилтийн орлого 4,9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.



Зураг 30 Хаягдал утааны хэмжилт хийж буй байдал

Түлшний хэмжилтийн жагсаалт

Хүснэгт-25

Түлшний хэмжилтийн жагсаалт										
№		Түлш үйлдвэрлэгч байгууллагын нэр	Зуухны төрөл	Хүчин чадал	Бохирдуулагч бодис /мкг/м3/-ээр				Нүүрсний төрөл	Нэмэлт бодис
					NO _x	SO ₂	CO	TSP		
1	2021/01/04	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжруулсан хатуу түлш	-
			Дөл	7кВт	433	1135	10779	108		
2	2021/01/19	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжруулсан хатуу түлш	-
			Дөл	7кВт	454	1184	15394	157		
3	2021/0	“Таван	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру	-

	1/21	толгой түлш” ХХК	Дөл	7кВТ	444	1047	10925	142	улсан хатуу түлш	
4	2021/0 1/21	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВТ	454	1184	15394	157		
5	2021/0 4/7	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВТ	190	122	14152	161		
6	2021/0 4/07	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВТ	357	1090	8819	146		
7	2021/0 4/12	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВ т	392	1040	7183	155		
8	2021/0 5/20	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВТ	322	787	8381	131		
9	2021/0 4/11	“Баялаг эрдэнэ цом” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВ т	331	1215	7857	141		
10	2021/0 4/11	“Баялаг эрдэнэ цом” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВ т	389	999	8977	139		
11	2021/0 4/13	“Каолин ланд бридж” ххк	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВ т	380	923	7603	145		
12	2020/0 4/13	“Каолин ланд бридж” ххк	MNS5216:2016		700	1200	9800	130	Сайжру улсан хатуу түлш	-
			Дөл	7кВ т	357	1009	9706	121		
13	2021/0 4/28	“Эко айдма”ххк	MNS5216:2016		700	1200	9800	130	Цаас	0,5кг
			Дөл	7кВ т	115	209	1552	10		

14	2021-05-03	“Эко айдиа” ххк	MNS5216:2016	700	1200	9800	130	Мод	-
			Дөл	7кВ т	99	373	5993		
15	2021/05/03	“Эко айлма” ххк	MNS5216:2016	700	1200	9800	130	Цаас	-
			Дөл	7кВ т	149	371	18930		
16	2021/05/03	“Ган эко монгол” ххк	MNS5216:2016	700	1200	9800	130	Тос	-
			Дөл	7кВ т					
17	2021/05/18	“ЭХЭЗХ” хк	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	168	1795	2934		
18	2021/07/08	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	398	880	12341		
19	2021/07/08	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	472	650	1131		
20	2021/07/15	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	472	650	17266		
21	2021/07/15	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	566	1006	15873		
22	2021/07/23	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	519	1077	21539		
23	2021/07/23	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	462	1105	14510		
24	2021/07/24	“Юу би сити тонголиа”	MNS5216:2016	700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	455	1018	12151		

25	2021/0 7/24	“Юу би сити тонголиа ”	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	446	997	13324	60		
26	2021/0 7/24	“Эм АЙ И”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	373	1634	10731	108		
27	2021/0 7/24	“Юу би сити тонголиа ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	323	1171	6680	125		
28	2021/0 8/11	“Уул уурайн хүрээлэн ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	219	972	12336	89		
29	2021/0 8/19	“Уул уурайн хүрээлэн ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	219	972	12336	89		
30	2021/0 8/19	“Уул уурайн хүрээлэн ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	281	702	17761	96		
31	2021/0 8/19	“Уул уурайн хүрээлэн ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	348	983	8466	114		
32	2021/0 8/19	“Уул уурайн хүрээлэн ”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	331	3492	9354	163		
33	2021/0 8/31	“МСРТ”Х ХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	159	43	5611	95		
34	2021/0 8/31	“МСРТ”Х ХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	506	489	7514	66		
35	2021/0 9/29	“Эн Эм Ту”ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	72	977	15000	674		

36	2021/0 9/29	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	374	673	9559	213		
37	2021/1 0/29	“Таван толгой түлш” ХХК	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	345	748	9286	149		
38	2021/1 1/19	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Түүхий нүүрс	-
			Дөл	7кВ т	536	2631	13292	1365		
39	2021/1 1/09	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Түүхий нүүрс	-
			Дөл	7кВ т	233	2067	11494	353		
40	2021/1 1/10	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	343	583	5823	182		
41	2021/1 1/11	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	207	508	10609	292		
42	2021/1 1/09	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	422	481	7960	381		
43	2021/1 1/10	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	335	1132	9055	214		
44	2021/1 1/11	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-
			Дөл	7кВ т	132	1688	6714	261		
45	2021/1	Эрчим	MNS5216:2016		700	1200	9800	130	Шахмал	-

1/09	хүчний эдийн засгийн хүрээлэн	Дөл	7кВ т	428	1570	6390	200		
------	-------------------------------	-----	-------	-----	------	------	-----	--	--

График 8




График 9




График 10





График 11



16. “Авто тээврээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах” зорилтын хүрээнд

1.Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын хэмжилтийн баг Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Эко майн системс” ХХК-иас ирүүлсэн тээврийн хэрэгсэлд суурилуулах зориулалттай “ECO Systems- Fuel enhancer” төхөөрөмжинд 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хэмжилт хийсэн.

Энэхүү төхөөрөмж нь бензин болон дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлд суурилуулах зориулалттай. Хэмжилтийн дүнгээс үзэхэд тээврийн хэрэгслийн яндангаар хаягдаж байгаа бохирдуулагч бодис CO /угаарын хий/, NOx /азотын нэгдлүүдийг/ 36 хувиас 100 хүртэлх хувиар бууруулсан үр дүн гарсан.

Хэмжилтийн хүснэгт 26. Тээврийн хэрэгслийн үндсэн мэдээлэл

Тээврийн хэрэгслийн мэдээлэл	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Моторын багтаамж	Шатахууны төрөл
------------------------------	--------------	--------------------	------------------	-----------------

Форд экспедишн	УНУ3899	2012	5400сс	бензин
----------------	---------	------	--------	--------

Хэмжилтийн хүснэгт 27. Харьцуулсан хэмжилт /CO/

Моторын эргэлтийн хурд	Хэмжилтийн хугацаа	Төхөөрөмж суурилуулаагүй үеийн Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	Төхөөрөмж суурилуулсан үеийн Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/	Буурсан хэмжээ	
		мг/м ³	мг/м ³	мг/м ³	%-иар
Моторын эргэлт 1000rpm үед					
1000	1	89	3	86	97
	1	254	3	251	99
	1	270	2	268	99
Моторын эргэлт 3000rpm үед					
3000	1	286	181	105	36
	1	272	113	159	58
	1	266	1	265	99

Хэмжилтийн хүснэгт 28. Харьцуулсан хэмжилт /NOx/

Моторын эргэлтийн хурд	Хэмжилтийн хугацаа	Төхөөрөмж суурилуулаагүй үеийн Азотын ислүүд /NOx/	Төхөөрөмж суурилуулсан үеийн Азотын ислүүд /NOx/	Буурсан хэмжээ	
		мг/м ³	мг/м ³	мг/м ³	%-иар
Моторын эргэлт 1000rpm үед					
1000	1	4	1	3	75
	1	13	0	13	100
	1	18	0	18	100
Моторын эргэлт 3000rpm үед					
3000	1	55	9	46	84
	1	60	25	35	58
	1	45	3	42	93



Зураг 31 Автомашины хэмжилт хийж буй байдал

2. НАБТГ-ын АЧХЗБХ-ээс хариуцан ОББҮХ-той хамтран “Тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад төрийн байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт цахим семинарыг 2021 оны 03 дугаар сарны 19-ний өдөр зохион байгуулсан.

3. Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор Сүхбаатарын талбайд 2021 оны 9 дүгээр сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан “Өнтэй өвөлжье”-ийн өдөрлөгийн хүрээнд байгууллагын хэмжилтийн үйл ажиллагааг сурталчилах, Сүхбаатарын талбай орчмын 2 өдрийн агаарын чанарыг тодорхойлох, дизель болон газан автобуснуудад харьцуулсан хэмжилт хийж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр сурталчилж ажилласан. “Өнтэй өвөлжье” өдөрлөгийн үеэр Сүхбаатарын талбай дээр хийсэн орчны агаарын чанарын хэмжилтийг PM2.5, PM10 тоосонцроор тодорхойлсон.

Хэмжилтийн хүснэгт 28. Нийтийн тээврийн автобусанд хийсэн харьцуулсан хэмжилт

Үзүүлэлт		CO мкг/м ³	SO ₂ мкг/м ³	NO ₂ мкг/м ³
2021.09.11	Дизель автобус	1078	38	268
	Газан автобус	407	14	88

Зураг 31



4. Монгол улсын нутаг дэвсгэр дээр авто замын хөдөлгөөнд оролцож байгаа бүх төрлийн тээврийн хэрэгслийн хаягдал утаанд 2 төрлийн стандартыг хүчин төгөлдөр мөрдөж байна. Үүнд:

1. Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 09-р сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан

2. Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014 : 2009 Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 9-р сарын 30-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан.

5. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны “Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 19/03 дугаар тогтоолын 1.3-т тусгагдсан “Зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс илүү бохирдуулах бодис ялгаруулж байгаа болон утааны шүүлтүүргүй дизель хөдөлгүүртэй автобус, ачааны автомашиныг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Нийслэлийн замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажиллах” заалтын хүрээнд: Нийслэлийн агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөөгийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан 2021/03 тоот удирдамжийн дагуу “Автотээврийн хэрэгслийн яндангаас гарах дуу чимээ,

ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх хяналт, хэмжилтийг 2021 оны 9 дүгээр сарын 21-22-ний өдрүүдэд хийсэн. Хэмжилтийн дүнгээр 36 дизель тээврийн хэрэгслийн 35 буюу 97%-нь стандартын шаардлагад нийцээгүй байсан бол бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн 7.3%-нь стандарт хангаагүй гэсэн дүн гарсан.

Хүснэгт-29

Бинзен хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн хаягдал утааны стандарт хангалтын байдал

№	Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэл	Үйлдвэрлэсэн он	Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Стандарт 3,5тн-оос доош утааны найрлагад эзлэх %-иар	Стандарт хангалтын байдал
1	toyoto	2008	0.99	1	тэнцсэн
2	toyoto	2014	0	1	тэнцсэн
3	daihatsu	2000	0.48	1	тэнцсэн
4	allion	2010	0	1	тэнцсэн
5	mitsubishi	2019	0	1	тэнцсэн
6	spacio	2002	0.07	1	тэнцсэн
7	suzuro	2021	0.01	1	тэнцсэн
8	suboru	2004	0.03	1	тэнцсэн
9	suboru	2004	0.14	1	тэнцсэн
10	toyoto	2000	0.33	1	тэнцсэн
11	nissan	2007	0.01	1	тэнцсэн
12	toyoto	2004	1.48	1	тэнцээгүй
13	mark2	2009	0	1	

Дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн хаягдал утааны стандарт хангалтын байдал

Хүснэгт-30

№	Үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэл	Үйлдвэрлэсэн он	Тортогжилтын хэмжээ	Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Чөлөөт хурдатгалын горимд, %-иар	Стандарт хангалтын байдал
1	porter	2000	100	35	тэнцээгүй
2	porter	2002	100	35	тэнцээгүй
3	bus	2011	40.9	35	тэнцээгүй
4	bus	2011	95.9	35	тэнцээгүй
5	kanter	1996	75.9	35	тэнцээгүй
6	bongo	2005	100	35	тэнцээгүй
7	porter	2011	100	35	тэнцээгүй
8	howo	2011	57.7	40	тэнцээгүй
9	bus	2011	99.4	35	тэнцээгүй
10	hino	1998	98.3	40	тэнцээгүй
11	hino	1998	92.7	40	тэнцээгүй
12	porter	1999	50	35	тэнцээгүй
13	shacman	2019	10.6	35	тэнцээгүй

14	hyundai	2005	72.6	35	тэнцээгүй
15	bongo	2006	100	35	тэнцээгүй
16	hyundai	2011	42	40	тэнцээгүй
17	hyundai	1998	51.6	40	тэнцээгүй
18	bongo	2006	100	35	тэнцээгүй
19	kia	2012	53.1	35	тэнцээгүй
20	mitsubishi	1998	89.7	35	тэнцээгүй
21	fuso	1989	89.7	40	тэнцээгүй
22	bongo	2005	100	35	тэнцээгүй
23	istana	2001	96.8	35	тэнцээгүй
24	istana	2003	92.8	35	тэнцээгүй
25	starex	2003	100	35	тэнцээгүй
26	bongo	2003	41	35	тэнцээгүй
27	isuzu	1989	85.6	35	тэнцээгүй
28	bongo	2001	100	35	тэнцээгүй
29	bongo	2012	97.9	35	тэнцээгүй
30	porter	2005	71.6	35	тэнцээгүй
31	porter	1999	85.2	35	тэнцээгүй
32	porter	2013	77.1	35	тэнцээгүй
33	howo	2011	30.5	40	тэнцээгүй
34	daewoo	2002	28.8	40	тэнцээгүй
35	автобус	2011	100	40	тэнцээгүй
36	bongo	2012	19	35	тэнцсэн

Зураг 32



17. Нийслэлийн томоохон авто замын уулзварын дагуу агаарын чанарын хэмжилт 1 удаа хийгдсэн байна.

“Тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад төрийн байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт цахим хурлаас гаргасан саналыг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраас ЦЕГ-ын харьяа Тээврийн цагдаагийн алба, ЗТХЯ-ны харьяа Авто тээврийн Үндэсний төв ТӨҮГ-т Нийслэлийн авто замын хөдөлгөөнд оролцож байгаа утаа ялгаруулж буй тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамжийн төслийг боловсруулсан. Энэхүү шалгалтаар Нийслэлийн 6 дүүргийн авто зам дээр Тээврийн Цагдаагийн алба, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Агаарын тухай”, “Автотээврийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, Монгол Улсын Их хурлын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 02 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар

тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл болон эрх бүхий байгууллагаас гаргасан дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, автотээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утааны найрлага дахь хорт бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байгаа эсэх, яндангийн дууны төвшинг шалган тогтоож үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгах, Нийслэлийн томоохон автозамын уулзварын дагуу агаарын чанарын хэмжилт хийх, хэмжилт, хяналт шалгалтанд тулгуурлан арга хэмжээний санал зөвлөмж гаргаж ажилласан. Шалгалтын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 01-нээс 9 дүгээр сарын 30-ныг хүртэл зохион байгуулсан.

18. Жайка олон улсын төслийн байгууллагатай хамтран ажиллах

1. Японы олон улсын хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 3 дугаар үе шат төслийн ажлын хэсэгт хамтрагч талаар “Таван толгой түлш” ХХК-иас холбогдох албан тушаалтныг оруулахаар зөвшилцөөд байна.

2. Төслийн хамтран зохицуулах хорооны гишүүн Эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын даргаар шинээр томилогдсон И.Лувсанрэнцэнтэй даргатай 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр уулзаж төслийн үйл ажиллагааг танилцуулан ажилласан.

3. Төслийн зүгээс “Таван толгой түлш” ХХК-д 2020 онд хүлээлгэн өгсөн биомассын бутлуурын төхөөрөмжийн суурилуулах үйл ажиллагааг эрчимжүүлэхээр “Таван толгой түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэрийн дарга Болдбаяртай төслийн дэд дарга Нацужи Савакигийн хамт 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр уулзаж дээрх бутлуурыг зүүн бүсийн үйлдвэр дээр суурилуулахаар шийдвэрлэсэн.

4. Төслийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 09-өөс 10-ны хооронд автомашины хаягдал утааны хэмжилт хариуцсан ажилтан Жүн Окабэгийн хамт автомашинд суурилуулсан хаягдал утааны хийн хэмжилтийн төхөөрөмжийг 92-37 УАА улсын дугаартай ачааны тэрэг дээр хэмжилт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

5. Японы автобусны компани, ачаа тээврийн компанид өргөнөөр нэвтрээд байгаа эко-жолоодлогыг Монголд нэвтрүүлж ашиглах боломж, түүнд холбоотой асуудлыг судлах зорилгоор автомашины жолоодлогын үеийн хэмжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 12, 15 – ны өдрүүдэд хийсэн.

6. Жайка төслийн мэргэжилтэний автомашины хаягдал утааны хэмжилтийн онол, багаж төхөөрөмжийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх үүднээс хэмжилтийн мэргэжилтэнд зориулсан мэдээллийн дата боловсруулах сургалтад 2021 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд хамрагдсан.

7. Төслийн хамтран зохицуулах хорооны болон хамтрагч талуудын хурлыг 2021 оны 12 дугаар сарын 6, 9-ний өдрүүдэд тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн. Дээрхи хурлуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

8. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны ажлын албаны нарийн бичиг бөгөөд Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дэд дарга А.Мөнхжаргал, төслийн дэд дарга Нацужи Саваки, Жүн Окабэ нарыг төслийн хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын тайлан болон хамтын ажиллагааг сайжруулах хурал зохион байгуулж ажилласан.

9. Сургалтанд оролцож чадаагүй мэргэжилтэн Б.Бямбацэцэгт мэдлэг дамжуулах сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хэмжилтийн дата боловсруулах чиглэлээр сургалт зохион байгуулсан.

Зураг 33



19. Гэр хорооллын дунд байрлалтай шороон замуудад хэмжилт хийж, автомашины хөдөлгөөний эрчмээс дэгдэх тоосонцрын оршин суугчдын эрүүл мэндэд нөлөөлөл нөлөөллийг тодорхойлох

Улаанбаатар хотын гэр хорооллын дундах шороон хучилттай замуудад хэмжилт хийх зорилгоор Нийслэлийн Авто замын хөгжлийн газраас 2021 онд гэр хороололд тавигдах замын байршлын мэдээллийг ирүүлэх тухай албан хүсэлтийг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/214 дугаарт албан бичгээр хүргүүлээд байна.

Гэр хорооллын дунд байрлалтай шороон замуудад хийсэн хэмжилтийн дүнг танилцуулах, гэр хорооллын дундах шороон замаас үүдэлтэй тоосжилтыг бууруулах зорилгоор нөлөөллийн ажлыг НАЗХГ-тай хамтран ЧД-ийн 16-р хорооны шинээр тавьсан засмал, тохижуулсан талбай дээр хороодын иргэдтэй хамтран зохион байгуулсан. Сурталчилгаа нөлөөллийн үйл ажиллагааг Ийгл телевизээр сурталчилсан



Зураг 34. Гэр хорооллын дундах шороон хучилттай замуудад хэмжилт хийж буй байдал

20. Автомашинтай болон автомашингүй өдрийн харьцуулсан хэмжилт хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан удирдамжын дагуу 2021 оны 1 дугаар сарын 15-наас 2 дугаар сарын 15 хүртлэх хугацаанд 2021 оны 12 дугаар сард хөл хорио тогтоосон замуудад хийсэн хэмжилтийн цэгүүдийг давхцуулан Улаанбаатар хотын томоохон авто замын уулзварын

орчимд орчны агаарын чанарын хэмжилтийг Сүхбаатарын талбайн зам дагуу, Бөмбөгөр-ийн урд зам, 32-ын тойрог, Баянбүрдийн тойрог, Саппоро, Офицерийн тойрог, Тэмээтэй хөшөөний уулзваруудад хөдөлмөрийн аюулгүй байдал, халдвар хамгаалалтын дэглэмийг баримтлан хийсэн.

Хэмжилтээр хөл хорио тогтоосон үеийн авто замыг ердийн ачааллтай үетэй харьцуулахад Улаанбаатар хотын авто замын дагуу агаар дахь азотын давхар ислийн хэмжээ /NO₂/ 1,2-4,3 дахин, хүхрийн давхар ислийн хэмжээ /SO₂/ 0-4 дахин, PM2.5 тоосонцор 2-5 дахин, PM10 тоосонцор 2-5 дахин тус тус буурсан байна.

2020 оны 12 дугаар сарын 24-28, 2021 оны 2 дугаар сарын 14-ны өдөр Улаанбаатар хотын авто замын томоохон уулзваруудын орчимд авто замын ердийн ачаалалттай үед болон хөл хорио тогтоосон үеийн харьцуулсан хэмжилтийг PM10, PM2,5, SO₂, NO₂ үзүүлэлтээр хэмжилт хийхэд PM2,5 тоосонцор **4 дахин**, PM10 тоосонцор **3,8 дахин**, SO₂ /хүхрийн давхар исэл/ **2,2 дахин**, NO₂ /азотын давхар исэл/ **2,7 дахин** тус тус буурч, тухайн өдөр агаар цэвэршиж, дуу чимээ эрс буурч байсан нь ажиглалтаар болон хэмжилтийн үр дүнгээр тодорхойлогдсон. Энэхүү хэмжилтийн үр дүнг МҮОНРТ болон МАСС.мн цахим сайтаар дамжуулан олон нийтэд сурталчилсан.

Зураг 35.




Зураг 21.Мэдээ мэдээлэл өгч буй байдал

Хөл хорио тогтоосон үеийн хэмжилт

Хүснэгт 34

	Үзүүлэлт	PM2,5 мкг/м ³	PM10 мкг/м ³	SO ₂ мкг/м ³	NO ₂ мкг/м ³
1-р цэг	Сүхбаатарын талбайн уулзвар орчим /хөл хорио тогтоосон үе 2021.02.14/	39	41	25	28
2-р цэг	32-ын тойргийн уулзвар орчим /хөл хорио тогтоосон үе 2021.02.14/	38	42	59	34
3-р цэг	Бөмбөгөр худалдааны төвийн уулзвар /хөл хорио тогтоосон үе 2021.02.14/	31	32	27	22

Тайлбар: 2021.02.14-ны өдрийн 14:00-16:30 цагийн үеийн агаар бохирдуулагч бодисын хэмжээ



Зураг 22. 2021.02.14-ны өглөө 10:37 цагийн үеийн агаар дахь PM2,5

Зураг 23. Оройны 19:08 цагийн үеийн агаарын чанарын индекс

Авто замын ердийн ачаалалтай үеийн хэмжилт

Хүснэгт 35

Үзүүлэлт	PM2,5 мкг/м ³	PM10 мкг/м ³	SO ₂ мкг/м ³	NO ₂ мкг/м ³
1-р цэг Сүхбаатарын талбайн уулзвар орчим /ердийн ачаалалттай үе 2020.12.24/	198	200	110	88
2-р цэг 32-ын тойргийн уулзвар орчим /ердийн ачаалалттай үе 2020.12.28/	75	75	45	44
3-р цэг Бөмбөгөр худалдааны төвийн уулзвар/ердийн ачаалалттай үе 20201225/	165	168	97	96

21. Дотоод болон бусад нэмэлт ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ.

1. “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу 2021 оны намрын “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” 05 дугаар сарын 08-ны өдрийг тохиолдуулан Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан хаагчид, Иргэний Нисэхийн Үндэсний төвийн аюулгүй байдал хамгаалалтын албаны хамт олонтой хамтран Яармагийн 63 дугаар сургуулийн орчин тойронд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан 200 ширхэг суулгацыг тарьялаа.

2. АЧХЗБХ-ээс хэмжилтийн 2 баг ажиллах хүний нөөц бүрдсэн бөгөөд шаардлагатай үед түлш болон УХЗуухны хэмжилтийг хэмжилтийг бие даан 2 зэрэг хийх боломж бүрдүүлэхээр төлөвлөж байна.

3. Хэлтсийн хэмжилтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Суурин харуулын засвар үйлчилгээ бие даан хийх чадвар эзэмшүүлэх сургалт дадлагыг мэргэжилтэн Ч.Нэргүй хариуцан оператор, техникч Б.Адъяа-Очирт, орчны хөдөлгөөнт харуулын хэмжилт, засвар үйлчилгээ хийх сургалт, дадлагыг ахлах мэргэжилтэн М.Отгонбаяр хариуцан С.Алтансүх болон Б.Адъяа-Очирт, суурин эх үүсвэрийн хэмжилтийн сургалт дадлагыг У.Жаргалбаатар хариуцан Э.Энх-Амгалан, Б.Адъяа-Очир, С.Алтансүх нарт зааж, орлож ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Зураг 36.



Зураг 24. Суурин харуулын засвар үйлчилгээ хийж буй байдал

6. Цар тахлын дэгдэлтийн үед НОК-оос өгсөн үүрэг даалгаврын дагуу БГД-ийн 22 дугаар хороодод эргүүлийн үүргийг 02 дугаар сарын 24-нөөс 27-ны хооронд 4 удаа гүйцэтгэж, хороодийн иргэдэд хөл хорионы дэглэмийг баримтлуулан ажилласан.

Хүснэгт 36

№	Эргүүлээр ажиллсан огноо	Эргүүлийн нутаг дэвсгэр	Зөвлөмж тараасан, зөвөлгөө өгсөн аж ахуйн нэгж	Ариутгал хийсэн байгууллагаар явсан	Зөрчил гаргасан иргэний тоо
1	02/24	БГД-ийн 22-р хороо	5	5	50
2	02/25		7	3	32
3	02/26		2	5	21
4	02/27		5	8	22



Зураг 37. Эргүүлийн ажил гүйцэтгэц буй байдал

7. Газрын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Сайжруулсан түлшний нөөцлөлт, хангамжийн баазын түлшний савалгааны байдалд хяналт тавих зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр СХД-ийн 20, 1,2, 33 дугаар хорооны агуулах, хангамжийн баазууд дээр ажилласан.



Зураг 38. Сайжруулсан түлшний нөөцлөлт, хангамжийн баазын түлшний савалгааны байдал хяналт тавьж ажиллаж буй байдал

8. Шадар Сайдын 2020 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэд технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр СХД-ийн 129 дугаар сургууль, цэцэрлэгийн халаалтын зууханд харьцуулсан хэмжилт хийлээ.

Хэмжилтээр хаягдал утааны найрлага дахь SO₂, NO_x, TSP, CO, бохирдуулах бодисын хэмжээг нүүрсэн галлагаатай зуух болон шингэрүүлсэн зуухтай харьцуулан хийлээ.

Хэмжилтийн үр дүнд нүүрсэн галлагаатай зуухыг шингэрүүлсэн зуух руу шилжүүлэхэд агаарт хаягдах бохирдуулагч бодисын хэмжээ 23%-99% буурсан үр дүн гарсан.

Шингэрүүлсэн хийн галлагаатай зуух

Хүснэгт 37

д/д	Байршил, дүүрэг, хороо	Эзэмшигч иргэн, аж ахуйн нэр, хаяг	Хийн халаалтад шилжүүлэхээс өмнө Зуухны тоо, марк MNS 5043:2016	Бохирдуулагч бодисын хэмжээ /мг/м3/			
				SO ₂	No _x	CO	TSP
				800	450	5000	600
1	СХД 9-р хороо	129-р сургууль, цэцэрлэгийн цогцолбор	Китурами 300кВт	785	287	4812	722

Нүүрсэн галлагаатай зуух


Хүснэгт 38

д/д	Байршил, дүүрэг, хороо	Эзэмшигч иргэн, аж ахуйн нэр, хаяг	Хийн зуухны хүчин чадал, марк Хийн бойлерын тоо, марк, хүчин чадал	Бохирдуулагч бодисын хэмжээ /мг/м3/			
				SO ₂	No _x	CO	TSP
1	СХД 9-р хороо	129-р сургууль, цэцэрлэгийн цогцолбор	16 ш, Daesung 52, 2 кВт	0	10-23	14-35	0
Агаар бохирдуулагч бодисын бууралт %-иар				100%	97%	98%	100%

Хэмжилтийн үр дүнг zasag.tur.mn mass.mn зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж ажиллаа.

9. Сайжруулсан түлш болон Багануурын түүхий нүүрс хэрэглэж байгаа Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг болон Налайх дүүрэгт явуулын AQMS-9000 станцаар 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хэмжилт хийсэн. Сонгино хайрхан дүүрэг, Налайх дүүрэгт хийсэн нэг өдрийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнг харьцуулахад

График 11



Налайх болон сонгинохайрхан дүүргийн өрхийн өсөлт, бууралтын өөрчлөлтийг 2016-2019 оны хооронд байдаар авч үзэхэд дараах байдлаар өөрчлөгдсөн байна.

График 12

График 13





График 14



- Сайжруулсан түлшний тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад гарч буй

хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллахад санал солилцох тулгамдаж буй асуудлуудын талаар зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 06 дугаар сары 04-ний өдөр зохион байгуулсан. Тус уулзалтаар 35 тээврийн аж ахуйн нэгж байгууллагын удирдлага болон холбогдох төлөөллүүд оролцож санал солилцсон бөгөөд цаашид тээвэрлэлтэд учирч буй асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхэд хамтран ажиллах талаар саналыг гаргасан.

Зураг 39



• Нийслэлийн Засаг даргын "Нийслэлийн 2020-2021 оны өвөлжилтийн дүн, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай" А/382 дугаар захирамжийн хүрээнд нийсэлийн агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөөгийн баталсан удирдамжийн дагуу нийслэлийн 6 дүүргийн ЗДТГ-тай хамтран 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах, гэр сууцаа дулаалах, сайжруулсан түлшний зөв галлагааны талаарх зөвлөмж мэдээлэл, заавар зөвлөгөө өгөх сургалтыг 2021 оны 08 дугаарын сарын 28—наас 09 дүгээр сарын 07-ны өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Сургалтад 6 дүүргийн гэр хороолол бүхий 99 хорооны зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар, орон тооны бус ажилтнууд 4500 хүн хамрагдсан.

Зураг 40.



• Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрсийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, Нийслэлэийн Засаг даргын 2021 оны А/382 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах, агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг танилцуулах, байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай шинэлэг дэвшилтэт техник, технологи, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагууд бараа бүтээгдэхүүнээ иргэд олон нийтэд танилцуулах, сурталчлах зорилготой "Өнтэй өвөлжье" өдөрлөгийг 2021 оны 09 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд халдвар хамгааллын дэглэмийг

чанд сахин зохион байгуулсан. Тус өдөрлөгт 30 гаруй төрийн байгууллага болон, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон.

Зураг 41



• Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын олон нийтэд ил тод нээлттэй болгох, өвөлжилтийн бэлтгэл хангуулах зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон инженерийн хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах “Нээлттэй хаалга, нэг сар аян” өдөрлөгт тус байгууллагын бусад хэлтэстэй хамтран оролцож байгууллагын үйл ажиллагааг сурталчилан танилцуулж ажилласан.

Зураг 42



Өдөрлөгийн үйл ажиллагаанд агаар, орчны бохирдлын хяналт шилнжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ногоон титэм” ХХК-ийг урьж оролцуулсан бөгөөд тус компаниас 80 гаруй угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг борлуулж, иргэдэд төхөөрөмжийн ажиллагааны зааварчилгаа өгсөн.

• Шинжлэх Ухааны Академи, Физик технологийн хүрээлэнтэй гэрээ байгуулан Улаанбаатар хот дахь агаарын бохирдол ихтэй бүсүүдийн агаар дахь микро элементийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг хамтран хийж байна. 2021 оны 10 дугаар сараас буюу халаалтын улирал эхэлсэнтэй холбогдуулан агаарын бохирдлыг хэмжих суурин харуулуудын цэгүүдэд хөвд байршуулах цэг тогтоох ажил хийгдээд байна.

• Гэр хорооллын айл өрх, иргэдэд чиглэсэн цахилгаан халаагуур, дулаан алдагдлыг бууруулах, эко жорлонгийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос “Ногоон зээл”-ийг санхүүжүүлж, арилжааны банкуудтай хамтран ногоон зээлийг 2021 онд дулаалгын 8, цахилгаан болон бусад халаагуурын 20, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны 10 аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулаад байна. Энэ ажлын хүрээнд агаар, орчны бохирдлыг бууруулах

байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг олон нийтэд сурталчлах, гэр, байшингийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад дэмжлэг үзүүлэх, хүү багатай зээлийн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих зорилгоор “Хас” банкны “Эко зээл”-ийн хэлтэстэй хамтран 2021 оны 11 сарын 16-17-ны өдрүүдэд “Ногоон зээл”-ийг иргэдэд таниулах өдөрлөгийг Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 140 гаруй хэсгийн ахлагч нарт зохион байгуулсан.

Зураг 43



• Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 12 дугаар хуралдаанаар Сайжруулсан түлшний хэрэглээг хянах Сайн картны бүртгэлийг үндэслэн Нэг өрх-Нэг карт ажлыг зохион байгуулж дуусгах үүрэг өгөгдсөний дагуу Нийслэлийн мэдээлэл технологийн газар Улсын Статистикийн хороо зэрэг газруудын холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулсан. Улсын Статистикийн хороо Таван толгой түлш ХХК, Ухаалаг шийдэл ХХК-ийн хооронд мэдээлэл солилцох сервер системийг сайжруулах, бүртгэлийн давхардсан мэдээллийг арилгах талаар гэрээ байгуулан ажиллаж байна.

22. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд:

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг Засгын газраас дэлхий нийтийг хамраад буй цар тахалтай холбоотойгоор тэмдэглэхгүй байхаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор байгууллагын ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлгийг эцэх эхээр нь дамжуулан хүргүүлсэн.



Зураг 44. Хүүхдийн баярын бэлэг бэлдсэн байдал

• Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран албан хаагчдынхаа хүүхдүүд дундаас Авьяас чадвар, сурлага хөдөлмөрийн үнэлж Шилдэг хүүхэд медалиар 4 хүүхэд, Авьяас чадвар, урлаг, спорт, сурлага хөдөлмөрийн үнэлж Хүрэл медалиар 6 хүүхдийг тус тус шагнав.

Зураг 45.



Албан хаагчдын хүүхдүүдэд медал гардуулсан байдал

23. НАБТГ-ийн дэргэдэх залуучуудын зөвлөл

Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалаар байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл” байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсгийн анхны хуралдаан өнөөдөр /2021.05.28/ болж Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан хаагчид, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга болон хамтран ажилладаг сайжруулсан түлшний тээврийн компанийн төлөөллүүд оролцож байна. Уг хуралдаанаар залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачилгыг дэмжих зорилгоор төр болон хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулахаар залуу үеийн төлөөллүүдтэй хамтран ажиллахаар болсон.

Зураг 46.



24. “ӨГӨӨМӨР ӨДӨР” арга хэмжээг зохион байгуулсан

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өгөөмөр өдөр” арга хэмжээнд Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан хаагчид идэвхтэй хамрагдаж ном, дэвтэр, гутал хувцас зэрэг хэн нэгэнд хэрэг болох зүйлийг хандивласан. Тус ажлыг зохион байгуулж цугларсан эд зүйлийг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэж өгч ажилласан.

Зураг 47.



“Өгөөмөр өдөр” арга хэмжээний хүрээнд цугласан зүйл

25. “Сайжруулсан түлшний цогц шийдэл” аяны хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Тавантолгой түлш ХХК, бусад албаныхантай хамтран “Сайжруулсан түлшний цогц шийдэл” аяныг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс “Утаагүй, Угааргүй, Ухаалаг хэрэглээ” уриатайгаар угаарын эрсдэл өндөртэй гурван сарын турш зарласан. Аяны хүрээнд угаарын хийн эрсдэлээс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, угаарын хийн эрсдэлгүй байх зорилт тавин ажиллаж байгаа юм.

Тус аяны хүрээнд олон нийтэд хүргэх постер, шторкыг “Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар”-ын албан ёсны цахим хуудас <http://aprd.ub.gov.mn/>, болон Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, хамтран ажилладаг 4 сайтаар олон нийтэд хүргэж ажилласан. Мөн тус аяны хүрээнд хийсэн ажлын тайланг Байгаль, орчин аялал жуулчлалын яамны холбогдох мэргэжилтэнд 3 удаа хүргүүлж ажилласан.

Зураг 48.



“Сайжруулсан түлшний цогц шийдэл” аяны нээлт, постер

26. “Хотын соёл” аяныг “Соёлтой БолГоё” аяны хүрээнд

Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн

2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хотын соёл” аяныг “Соёлтой БолГоё” уриатайгаар 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд зохион байгуулж байгаа билээ.

Тус аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх 9 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хийж хэржүүлсэн ажлын тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст нийт 5 удаа хүргүүлж ажилласан.

27. “Нээлттэй хаалга, нэг сар” аянд оролцон зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын олон нийтэд ил тод нээлттэй болгох, өвөлжилтийн бэлтгэл хангуулах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/746 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, инженер хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах, “Нээлттэй хаалга, нэг сар” аянд тус газар нь 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдөр оролцон холбогдох мэдээлэл шуурхайг хүргэн ажилласан.

Зураг 39.



Зураг 49. “Нээлттэй хаалга, нэг сар” аянд оролцож буй байдал

28. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэх ажлын хүрээнд:

Ойн тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээ 2021 оны 10 дугаар сарын 04-10-ны өдрийг хүртэл үргэлжилсэн. Тус газрын албан хаагчид 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Нийслэл хотод сонгон авсан 4 байршлын “Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо, Баруун салаа, Бумбатын булаг” байршилд нийт 55 хайлааст модны үрсэлгээг суулган “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн халдвар хамгааллын дэглэмээ сайн барин идэвхитэй оролцсон.

Зураг 50.



29. Сайжруулсан түлшний борлуулалтын цэгт хяналт ажилласан тухай:


Нийслэлийн ИТХ-ын 2021 оны 121 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/779 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны 11 сарын 08-ны өдөр баталсан хуваарийн дагуу Захиргааны хэлтсийн дарга Ж.Балжинням, Оператер техникч У.Жаргалбаатар, диспетчер А.Даваахүү нар нь Баянзүрх дүүргийн 5,9,12, 19,20, 21 дүгээр хороодуудад байрлах сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгүүдээр 2021 оны 11 дүгээр сарын 14-ны Бүтэн сайн өдөр явж хяналт, шалгалтыг хийсэн болно.

Хяналт, шалгалтыг 144 борлуулалтын цэгүүдээс 61 борлуулалтын цэгт хяналт хийсэн.

Өмнөх 7 хоногт БНХАУ-ын Эрээн хот хилээ хаасантай холбоотойгоор түлшний уут тасарч 100кг-аар том хэмжээгээр савлагдан үйлдвэрээс гарч байсантай холбоотойгоор иргэдэд ихээхэн хүндрэл учруулж байна. Энэ нь 7 хоногт 6 шуудай түлш авахаас 4 шуудайг нь авч байна. Хүнд авч явахад хэцүү байсан. Одоо харин 25 кг шуудайгаар савлан түлш ирж иргэд бухимдал багассан.

Дүүрэгт ажиллах хугацаанд борлуулалтын цэгүүдэд элдэв зөрчил, дутагдал илрээгүй бөгөөд цэгүүдэд түлшний хангалт сайн байсан болно.

Зураг 51.



Борлуулалтын цэгт ажиллаж буй байдал

30. Мэтгэлцээний тэмцээнд албан хаагчид оролцсон.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны төвөөс санаачлан Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойн өдрийг угтан албан хаагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан мэтгэлцээний тэмцээнд албан хаагчдыг оролцуулж багаараа мэдлэг оюунаараа уралдан дэд байранд шалгарсан.

Зураг 52.



Мэтгэлцээний тэмцээн

31. Сургалтад хамрагдсан байдал:

НЗДТГ-ын дэргэдэх НССТ-өөс зохион байгуулсан MS Excel программын анхан, дунд шат, 2022 онд мөрдөгдөх шинэчлэн батлагдсан, Шинээр мөрдөгдөх хуулийн талаар /ublegal.mn/, Төрийн албан хаагчийн манлайлал, гэрч хохирогчийг хамгаалах нь, ялгаварлан гадуурхалт, Авлига, авлигын шалтгаан нөхцөл, Төрийн албаны зөвлөлөөс үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болон төрийн албаны шинэтгэл, төрийн албаны хүртээмжийн удирдлагад цогц чадамж эзэмшүүлэх, төрийн албаны хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, анхаарах асуудлууд, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан МУ-ын Жендэрийн нөхцөл байдал, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ цахим сургалтад тус тус хамрагдсан.

Зураг 53.



Цахимаар сургалтад хамрагдаж буй байдал

32. Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1 зорилт бүхий 3 арга хэмжээний 4 заалтын хэрэгжилтийг 85%,
- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилт 4 арга хэмжээний 13 заалтын хэрэгжилтийг 92.3%,
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилт бүхий 2 арга хэмжээний 6 заалтын хэрэгжилтийг 86,6%-тай ханган биелэлтийг нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээ хийж 85 хувьтай биелсэн гэж дүгнэн байгууллагын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлцүүлэн хурлын тэмдэглэлийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагын "Дотоод хяналт" хийх ажлын хэсэг байгуулан тухай бүрт удирдамж гарган газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны 03 сарын 16-ны өдрийн "Албан хаагчдын ажлын байранд гүйцэтгэх ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын удирдамж"-ийн хүрээнд Нийслэлийн төвийн зургаан дүүрэгт байрлах сайжруулсан түлш хадгалах, нөөцлөх Хангамжийн бааз болон агуулахад ээлжээр ажиллах гэрээт албан хаагч буюу диспетчерүүдийн ажлын байрны цаг ашиглалт, агуулах, хангамжийн баазын стандартад 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөс 04 дүгээр сарын 08-ны өдрүүдэд хяналт хийж ажиллав. Хяналт шалгалтаар 4 агуулах, 4 хангамжийн баазын нөхцөл байдал, тус объектуудад гарч буй албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад гарсан зөрчилгүй агуулах, хангамжийн баазуудын үйл ажиллагаа хэвийн байсан.



Зураг 54. Албан хаагчдын ажлын байрны цаг ашиглалт, хяналт шалгалт хийн ажилласан байдал

-Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын орчны агаарын чанарын хэмжих суурин харуулын тоног төхөөрөмжийн ашиглалт, лабораторийн үйл ажиллагааны байдалд байгууллагын дотоод хяналтын ажлын хэсгээс хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх зорилгоор 2021 оны 12 сарын 26-ны өдрийн газрын даргын баталсан Удирдамжийн хүрээнд БГД, СХД, БЗД, ХУД, СБД-т байрлах суурин харуулууд, ХУД-т байрлах лабораторийн офисс, тусгай зориулалтын тээврийн хэрэгслүүд, түлшний лабораторийн үйл ажиллагаатай танилцан лабораторид ажилладаг албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахиж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч, Суурин харуулуудын байранд хяналт тавьж ажиллахад СБД, ХУД, СХД-ийн суурин харуулуудад хянах самбар нэг ажиллаж байсан бөгөөд бусад хянах дэлгэцүүдийн пилтер солих шаардлагатай болсон байсныг шуурхай сольж үйл ажиллагааг хэвийн явуулах заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Зураг 55.



-Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулсан хрэгжилтийг ханган ажиллаж байна. Оны эхний хагас жилээр Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ дах байгууллагын дансанд бүртгэлтэй 615 нэр төрлийн 183,158 ширхэг нийт 9,222,213,695.28 (есөн тэрбум хоёр зуун хорин хоёр сая хоёр зуун арван гурван мянга зургаан зуун ерэн таван төгрөг хорин найман мөнгө) үндсэн хөрөнгө, хангамжийн хөрөнгийг бүртгэлтэй тулган эд хариуцагч нарыг байлцуулан албан хаагчдын хөрөнгийн тооллогыг хийсэн. Мөн байгууллагын ажилтан, албан хаагч нар орсон гарсантай холбоотойгоор тухайн албан тушаал дээр өмч хариуцсан мэргэжилтэнд өмчийг шилжүүлэх, өмч актлах, жилийн эцсийн өмчийн тооллого хийх хэрэгцээ байгууллагад гарч үүнтэй холбоотойгоор дахин шинээр байгуулах шаардлагатай байсан тул 2021 оны 11 сарын 26-ны өдрийн даргын тушаалаар шинэчлэн баталсан. Өмч

хариуцсан мэргэжилтэнд өмчийг шилжүүлэх, өмч актлах, жилийн эцсийн өмчийн тооллогыг 2022 оны 01 дүгээр сард багтаан хийхээр төлөвлөсөн.

33. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд:

Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор “Жайка ОУ-ын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа “Агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл-3”-ын хүрээнд 5 удаа онлайн хурал зохион байгуулсан. Энэхүү хурлуудаар төслийн явцыг хэлэлцэж, хоцрогдолтой ажлуудыг хэрэгжүүлэх хуваарьт өөрчлөлт оруулах, Улаанбаатар хотын агаарын бохирдуулах эх үүсвэрүүдэд томоохон өөрчлөлт орсонтой холбоотойгоор эх үүсвэрүүдийн эзлэх хувь хэмжээг тодорхойлох судалгааг ЦУОШГ-тай хамтран хэрэгжүүлэх, НАБТГ-ын хөдөлгөөнт эх үүсвэр хариуцсан 2 мэргэжилтэнд АСХУХ-ын ур чадвар эзэмшүүлэх сургалт, 1-2 мэргэжилтэнд тархалтын загварын сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах, сайжруулсан түлшний туршилтын төсөл хэрэгжүүлэх байршил сонгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн.

- Азийн орнуудын агаарын чанарыг сайжруулах нэгдсэн хөтөлбөр төслийн хүрээнд 8 орны 53 оролцогчтой цахим сургалтанд ахлах мэргэжилтэн М.Отгонбаяр оролцож, 6 асуулгад санал өгсөн. Японы Жайка олон улсын байгууллагаас 2021.05.12 өдөр зохион байгуулсан “Эх үүсвэрээс үүдэлтэй агаар бохирдуулагч бодисын ялгарлыг тооцох” цахим сургалтад тус хэлтсийн 3 мэргэжилтэн оролцсон. Сургалтаар автомашинаас үүдэлтэй бохирдуулагч бодисын ялгарлыг хэрхэн тооцоолох, үйл ажиллагааны өгөгдөл хэрхэн цуглуулах, мөн ялгарлын коэффициент тооцоолоход шаардлагатай мэдээллийг нэгтгэх, боловсруулах зэрэг арга зүйн болон техникийн чадвараа нэмэгдүүлэн, цаашид бие даан тооцоолол хийх чадварыг эзэмшиж байна. Төслийн зорилгыг биелүүлэх явцад Орчны агаар болон бохирдуулах бодисын ялгарлын эх үүсвэрийн хяналт шинжилгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн үнэлгээ, Агаарын бохирдлыг бууруулах стратеги, бодлого, шийдвэр, Хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт гэсэн 4 шатлал бүхий агаар орчны хяналтын тогтолцоо бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллана.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас техникийн туслалцаагаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” (3-р үе шат)-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Уг төслийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 09-өөс 10-ны хооронд Жайка төслийн автомашины хаягдал утааны хэмжилт хариуцсан ажилтан Окабэ Жюн хамтран /АСХУХ/ төхөөрөмжийг ашиглан хэмжилт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Автомашинд суурилуулдаг хаягдал утаа хэмжигч (АСХУХ) үр дүн боловсруулах сургалтын дагуу хамгийн эхний хэмжилтийн дүнг боловсруулан гаргасан. Хэмжилтэд дизель хөдөлгүүрт нэг тээврийн хэрэгсэл ашигласан. Хэмжилтийн дүнгээр автомашин хөдөлгөөнд жигд хурдтай оролцох үед ялгарах Хүхрийн давхар исэл (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) хэмжээ ялгарал бага байсан бол хурд ихтэй болон удаан оролцож байх үед ялгарал ихсэж Хүхрийн давхар исэл (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) ихээр ялгарч байгаа үзүүлэлттэй байсан.

Мөн 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Төслийн багийн дэд дарга Саваки Нацужи суурин эх үүсвэрийн хэмжилтийн хүрээнд мэргэжилтэн бэлтгэх, багаж тоног төхөөрөмж

засварлах талаар сургалт зохион байгуулж тус газрын оператор, техникч У.Жаргалбаатар, Э.Энх-амгалан, С.Алтансүх нар хамрагдсан.

34. Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 100 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/1236 дугаар захирамжаар байгууллагын орон тооны хязгаарыг 39 хүртэл байхаар тогтоосон.

2021 оны эхний хагас жилийн байдлаар тус газар нь төрийн захиргааны 18, төрийн үйлчилгээний 18 (сайжруулсан түлшний үйлдвэр, дундын агуулахуудад 14 диспетчер), нийт 36 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд Төрийн албаны төв зөвлөлийн 2020 оны 103 дугаар тогтоолоор 17 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг, газрын даргын 2021 оны А/23 дугаар тушаалаар Байгууллагын ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинээр бий болсон төрийн үйлчилгээний 2 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан газрын даргаар 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр баталгаажуулсан.

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтын болон нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилт

Хүснэгт 39

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилто т түвшин (тоо, хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр(мян.төг)	Тайлбар
1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1. Хүний нөөцийг чадавхижуулах	1.	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас доошгүй	16 удаагийн сургалтад давхацсан тоогоор 104 албан хаагч хамрагдсан. 100%	0	1.ТАЗ-ийн сургалтад-11, 2.Удирдлагын академийн сургалтад-6 албан хаагчид хамрагдаж, 5 албан хаагч гэрчилгээ авсан. 3.НЗДТГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн сургалтад-54, /давхацсан тоогоор/, 4.Авлигатай тэмцэх газрын сургалтад-7,
			Албан хаагчдын хамрагдсан байдал	95 хувиас дээш	Давхацсан тоогоор 124 албан хаагч хамрагдсан. 100%		

							5.Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад-5, 6.“Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ үнэлгээ” сэдэвт сургалтад байгууллагын 22 албан хаагчид хамрагдсан, гэрчилгээ авсан. 7.Бусад байгууллагын сургалтад-29,
			Гадаад сургалта нд албан хаагчдын хамрагдсан байдал	10 хувиас дээш	JICA-ийн цахим сургалтад 25 албан хаагчид хамрагдсан. 100%	-	Дэлхий даяар тархаад буй цар тахал болох (COVID-19)-той холбоотойгоор албан хаагчид гадаадын сургалтанд хамраагдаагүй. Харин JICA-ийн 9 удаагийн цахим сургалтад-25, /давхацсан тоогоор/,
	2.	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	95 хувиас дээш	Төрийн жинхэнэ албан тушаалд 16, төрийн үйлчилгээний албан тушаалд 16 албан хаагч, нийт 36 албан хаагч ажиллаж байна. 100%	-	-
Хэсгийн дундаж: 100%							
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3.	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	“Алтан гадас” одонгоор 1, хөдөлмөрийн хүндэт медалиар 2, Салбар яамны шагналаар 7, Нийслэлийн	36,501,569	“Алтан гадас” одонгоор 1, хөдөлмөрийн хүндэт медалиар 2, ШУА-ын шагналаар 1, Төрийн албаны шагналаар 1, Салбар яамны шагналаар 5, УБ хотын Ерөнхий менежерийн

				<p>н ИТХ-ын шагналаар 7, Нийслэлийн ЗД-ын шагналаар 3, Ерөнхий менежерийн шагналаар 5, албан хаагчийг тус тус шагнагддад байна. 100%</p>		<p>шагналаар 5, Нийслэлийн ИТХ-ын шагналаар 7, НЗД-ын шагналаар 3 буюу нийт 22 албан хаагч шагнагдаад байна. ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тогтоолын хүрээнд албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэж, газрын даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар 17,493,091 төгрөгийн, Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 565 дугаар албан бичгийн дагуу газрын даргын 2021 оны А/76 дугаар тушаалаар 18,658,478 төгрөгийн урамшууллыг нийт албан хаагчдад олгоод байна.</p>
		<p>Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах</p>	<p>Гүйцэтгэлээр</p>	<p>14 албан хаагчид удаан жилийн нэмэгдэл, 12 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл олгосон. 100%</p>	<p>/ур чадварт 17,578,572 төг, зэрэг дэвийн нэмэгдэлд 15,726,198 төг, удаан жилийн нэмэгдэлд 9,125,867 төг буюу нийт 42,430,637 төгрөгийг</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/270 дугаар захирамжаар байгууллагын төрийн жинхэнэ 6 албан хаагчдад шинээр зэрэг дэв болон нэмэгдлийг олгосон бол ТҮ-ний нийт 16 албан хаагчдад</p>

						зарцуула ад байна.	ур чадварын нэмэгдлийг 10-25 хувиар газрын даргын 2021 оны А/30, А/89 дүгээр тушаалаар олгож байна.
		Цар тахал (COVID- 19)-өөс урьдчила н сэргийлэ х ажлын хүрээнд албан хаагчдыг н аюулгүй байлыг хангах	Гүйцэт- гэлээр (эргүүл- ийн хуваарь)	Давхацсан тоогоор нийт 216 албан хаагчдад 2 сар тутамд амны хаалт, гар ариутгагч болон бээлий олгосон. 100%	/2 сар тутамд нийт 7,259,800 төгрөг/- ийн халдвар, хамгаалл ын хэрэгсли йг олгоод байна.	Албан хаагчдыг корановирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаа сэргээх нэмэлт тунд 12 сарын байдлаар 23 албан хаагчдыг хамруулаад байна.	
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүү лэх	Гүйцэт- гэлээр	Албан хаагч бүрт сар тутам унаа, хоолны зардалд 110,000 төгрөг олгож байна. 100%	/унаанд 3,655,000 төг, хоолонд 32,895,00 0 төг буюу нийт 18,275,00 0 төгрөг/- ийг албан хаагчдад жилээр төсөвлөн зарцуула ад байна.		
4.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэ х	Гүйцэт- гэлээр	Газрын даргын 2021 оны А/40, А/98 дүгээр тушаалаар албан хэрэгцээнд 1 ширээ, 1 сандаг, 2 шүүгээ, 4 компьютер , 2 принтер худалдан авсан. 100%	/Суурин компьюте р /Dell OptiPlex, иж бүрэн/ 4 ширхэг болон бусад эд хөрөнгийг худалдан авахад нийт 13,712,50 0 төгрөг/- ийг ажиллах нөхцөлийг бүрдүүлэ хэд		

					зарцуула ад байна.	
		Ажилтан, албан хаагчдын хөдөлмөр ийн аюулгүй байдлыг хангах	Гүйцэт- гэлээр	Хөдөлмөр, аюулгүй ажиллагаа г хангах зорилтын хүрээнд 7,259,800 төгрөгийг зарцуулаа д байна. 100%	/Аюулгүй байдлын хамгаалл ын хэрэгсэл д 7,259,800 төг, төгрөг зарцуулс ан болно/.	Нийт 216 ажилтан, албан хаагчдад цар тахалын эрсдэлээс сэргийлэх зорилгоор амны хаалт, гар ариутгагч, бээлий зэргийг 2 сар тутамд олгосон.
Хэсгийн дундаж: 100%						
5.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Байгууллагын зүгээс “Буянтай ачтан” эмнэлэгтэй хамтран бүх ажилтан, албан хаагчдыг 9 дүгээр сарын 13, 15-ны өдрүүдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо нд хамруулсан 100%	0	Байгууллагын 2021 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд тусган, төлөвлөгөөний дагуу 9 дүгээр сарын 13, 15-ны өдрүүдэд нийт 35 албан хаагчдыг “Буянтай ачтан” эминэлэгтэй хамтран эрүүл мэндийн үзлэгт хамруулсан болно. Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран давхардсан тоогоор 43 албан хаагчдыг PCR- ийн шинжилгээнд хамруулан шуурхай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахын зэрэгцээ 2021 оны 09 болон 11 дүгээр саруудад

						дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунд нийт 22 албан хаагчдыг хамруулсан.
Хэсгийн дундаж: 100%						
Үнэлгээний дундаж хувь: 100%						

Албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор 2021 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, 2 дугаар сард газрын даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар давхацсан тоогоор 151 албан хаагчид дотоодын сургалт, семинарт оролцож, туршлага судалж, мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнийг дараах байдлаар авч үзвэл:

2021 оны эхний хагас жилийн байдлаар:

- Удирдлагын академийн Чиглүүлэх сургалтад 3 албан хаагчид суралцаж 2 албан хаагч нь амжилттай төгсөж, гэрчилгээ авсан.
- ТА3-өөс онлайнаар цуврал хэлбэрээр хүргэсэн Хүний нөөцийн албан хаагч нарт зориулсан 6 удаагийн сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн,
- JICA-ийн мэргэжлийн дагуу сургалтад давхацсан тоогоор 12 албан хаагчид,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ үнэлгээ” сэдэвт сургалтад байгууллагын 22 албан хаагчид хамрагдсан, гэрчилгээ авсан.
- Нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн 7 удаагийн сэдэвчилсэн сургалтад нийт давхацсан тоогоор 20 албан хаагчид,
- Салбар, чиглэлийн дагуу байгууллагуудын цахим сургалтад 14 албан хаагчид тус тус хамрагдсан бөгөөд давхацсан тоогоор 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 77 албан хаагчид сургалтад хамрагдсан болно.



Зураг 56. “Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ үнэлгээ” сургалтын гэрчилгээ
Албан хаагчид цахим сургалтад хамрагдаж буй байдал

Байгууллагын нийт 36 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилж, шинээр ажилд орсон 2 албан хаагчид хувийн хэрэг үүсгэж, холбогдох баримтуудыг дарааллын дагуу хавсарган хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан.

Байгууллагын албан хаагчдын “Ээлжийн амралт эдлүүлэх хуваарь”-ийг Газрын даргын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд уг тушаалтай уялдуулан төрийн албыг тасралтгүй жигд явуулах зорилгоор албан хаагчдын “Орлон ажиллах хуваарь”-ийг хавсралтаар гарган, баталгаажуулсан. 2021 онд нийт 37 ажилтан, албан хаагчид ээлжийн амралтаа биеэр эдлээд байна.

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх”, 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын хүрээнд байгууллагын албан хаагчдын 2021 оны ажлын гүйцэтгэлийг эхний хагас жилийн байдлаар үнэлж дүгнэх ажлыг Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй хамтран хийж байна.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд:

1. “Цагаан сар” билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнг тохиолдуулан байгууллагын 3 өндөр настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн дагуу газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар зардал гарган мөнгөн тэтгэмжийг олгосон;

2. Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын 0-16 насны нийт 80 хүүхэд багачуудад “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн дагуу 2,299,000 төгрөгийн үнэ бүхий гарын бэлгийг гардуулан өгсөн;

3. Хариуцсан үүрэгт ажилдаа амжилттай, үр бүтээлтэй ажиллаж төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор орлогч дарга Ц.Цолмон 2021 оны 02 дугаар сард, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар мэргэжилтэн Г.Гончигдорж нар тус тус шагнуулсан бол цаашид албан хаагчдыг урамшуулах зорилгоор Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан 8 ажилтан, албан хаагчийг шагнуулахаар байгууллагаас тодорхойлоод байна.



Зураг 57. “Алтан гадас” одонгоор шагнагдсан албан хаагчид хүндэтгэл үзүүлж буй байдал

4. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/270 дугаар захирамжаар байгууллагын төрийн жинхэнэ 6 албан хаагчдад шинээр зэрэг дэв болон нэмэгдлийг олгоод байна.

5. Төрийн үйлчилгээний 16 ажилтанд I дүгээр улирлын ур чадварыг 10-25 хувиар тооцон газрын даргын 2021 оны А/30 дугаар тушаалаар олгож байна.

6. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд албан хаагчдыг эрсдэлд оруулахгүй байх зорилгоор 10 хувийг ажлын байранд, үлдсэн хувийг гэрээсээ цахимаар ажиллуулах нөхцөлөөр ханган ажиллуулсан бол Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд нийт албан хаагчдын 50 хувийг ажлын байранд, үлдсэн 50 хувийг гэрээс нь цахимаар ажиллуулж байна.

7. Цар тахлын эрсдэлээс албан хаагчдыг сэргийлэх зорилгоор 36 ажилтан тус бүрт 2 удаа тус бүр 100 ширхэг амны хаалт болон халдвар хамгааллын хэрэгслийг олгосон.

Зураг 58.



8. Албан хаагчдынхаа хүүхдүүдийг идэвхжүүлэх, сурлага ур чадварыг нь дэмжих зорилгоор ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийслэлийн “Шилдэг хүүхэд” алт, хүрэл медалиар 11 хүүхдүүдэд шагналыг олгоод байна.



Зураг 59. Нийслэлийн “Шилдэг хүүхэд” алт, хүрэл медаль гардуулах арга хэмжээ

1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу гэр хороололд амьдардаг 16 ажилтан, албан хаагчдад газрын даргын 2021 оны Б/52 дугаар тушаалаар 1 тонн түлшний хөнгөлөлтийг байгууллагаас олгосон.

2. Ажил үйлсээрээ хамт олноо тэргүүлж ажилласан албан хаагчдыг Улсын баяр наадам, Нийслэлийн ойн баяр, Үндэсний бахархлын өдөр болон Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан холбогдох дээд шатны байгууллагуудад тодорхойлж, Төрийн албаны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1, ШУА-ын “Жуух бичиг”-ээр 1, БОАЖЯ-ны тэргүүний ажилтан цол тэмдгээр 4, яамны жуух бичгээр 1, НИТХ-ын шагналаар 7, Нийслэлийн Тэргүүний ажилтан цол тэмдгээр 3, УБ хотын Ерөнхий менежерийн өргөмжлөлөөр 3 албан хаагчид буюу нийт 15 ажилтан, хаагчид шагнагдаад байна.

Зураг 60.

Албан хаагчид шагналаа авч буй байдал



3. Төрийн үйлчилгээний 16 ажилтанд I, III дугаар улирлын ур чадварыг 10-25 хувиар тооцон газрын даргын 2021 оны А/30, А/89 дүгээр тушаалаар олгож байна.

4. Ковид-19 цар тахлын шинэ хуулбар тархсантай холбогдуулан байгууллагын албан хаагчдыг эрсдэлээс сэргийлэх зорилгоор 7 хоногийн ажлын 1 өдрийг гэрээсээ цахимаар ажиллуулах нөхцөлөөр ханган ажиллуулж байна.

5. Цар тахлын эрсдэлээс албан хаагчдыг сэргийлэх зорилгоор 36 ажилтан тус бүрт 9 болон 11 дүгээр саруудад тус бүр 50/50 ширхэг амны хаалт болон халдвар хамгааллын хэрэгслийг олгосон.

6. Дэлхий нийтээр тархаад буй цар тахал (ковид-19)-ын өндөр эрсдэлтэй орчин нөхцөлд ажиллаж, эрсдэлд орсон албан хаагчдыг Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 02-ны 12, 04 дүгээр сарын 07-ний өдөр 9, 04 дүгээр сарын 09-ний өдөр 6, 05 дугаар сарын 08-ны өдөр 9 буюу нийт давхардсан тоогоор 36 албан хаагчдыг PCR-ийн шинжилгээнд хамруулсан бол ажлын өрөө тасалгаанд мэргэжлийн байгууллагаар голомтын ариутгалыг 4 удаа хийлгэж урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч, албан хаагчдыг эрсдэлээс хамгаалан ажиллаж байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2021 оны 09 болон 11 дүгээр саруудад дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунд нийт 22 албан хаагчдыг хамруулсан.



Зураг 61. Албан хаагчдыг PCR-ийн шинжилгээнд хамрагдаж буй байдал Ажлын өрөөнд өдөр бүр халдваргүйжүүлэлт хийж байна

Засгийн газрын “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоол, НЗД-ын “Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 2017 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд газрын даргын 2021 оны А/29 дугаар тушаалаар “Байгууллагын ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан баталж, нийт албан хаагчдад танилцуулан, дагаж мөрдөж ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын цагийг автомат цаг бүртгэлийн системээр бүртгэн хяналт тавьж, хоцорсон, тасалсан цагийг цалингийн тооцоотой уялдуулан тооцож байна.

35. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Байгууллагын 2021 оны жилийн эцсийн байдлаар Удирдлагад 8, Захиргааны хэлтэст 468 бичиг, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 291, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 221 нийт 988 албан бичиг ирсэн байна. Үүнээс хариугүй бичиг 764, хариутай бичиг 224 буюу хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь **99.87 хувь**, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн тоо **98,89 хувьтай** байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 0.88 %-аар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 322 ирсэн албан бичиг цаасаар хүлээн авч, бүртгэлийн дэвтэр хөтөлж eDoc.ub.gov.mn програмд сайнердаж оруулан удирдлагад шилжүүлэн ажилласан. Явсан бичгийг тухай бүрт нь бүртгэлийн дэвтэрт бүртгэн нэг хувийг тогтмол хадгалан ажиллаж байна. Албан хаагчдаас ирүүлсэн албан бичгийн болон тушаалын төслийг боловсруулан хэвлэмэл хуудсанд стандартын дагуу хэвлэн бэлтгэн ажиллаж байна.

36. Байгууллагын хэмжээнд баримт бичгийг хянан шийдвэрлэсэн тухай мэдээ, тайлан

/2021.01.01-2021.12.02/

Хүснэгт 40


Д/д	Нэгж/хэлтэс	Хяналтанд байгаа баримт бичгүүд		Үүнээс:			
		Бүгд	Өнгөрсөн сард ирсэн	Хугацаанд нь шийдвэрлэсэн	Хугацаандаа шийдвэрлэгдэж байгаа	Хугацааг нь сунгасан	Хугацаандаа шийдвэрлэгдээгүй
1	Удирдлага	8	1	5	1	-	2
2	Захиргааны хэлтэс	468	117	463	3	-	2
3	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс	291	18	289	2	-	-
4	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс	221	14	216	3	-	2
	Нийт	988	150	973	9	-	6

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг өмнөх оны энэ үетэй харьцуулвал хугацаа хэтэрсэн албан бичгийн тоо 14- өөр бага, албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 1,57 хувиар багассан байна. Жилийн эцсийн байдлаар нийт 535 албан бичиг явуулсан ба өмнөх оны жилийн эцсийн шийдвэрлэлтийн хувиас 48.41 хувиар өссөн ба 100% - тай шийдвэрлэсэн байна. Цаашид албан бичиг шийдвэрлэлтийн хугацаанд анхаарч зөрчлийн тоог багасгах талд анхааран ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар зөрчлийн мэдээг хүснэгтээр харвал шийдвэрлэх хугацааны зөрчил 40 болтол багасч, албан бичиг шийдвэрлэлтийн зөрчил 0, стандартын зөрчил 0 болсон байна. Цаашид зөрчлийн тоо үзүүлэлт багасгах тал дээр анхаар нийт албан хаагч нарт сургалт орсон стандартын болон баримт бичгийн шийдвэрлэлтэнд анхааран мэргэжилтэнгүүдэд зөвөлгөө өгч ажиллаж байна.

37. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээ

График 14



Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан 2021 оны 03 сарын 04-нд архив албан хэрэг хөтлөлт болон edoc програмын сургалтад нийт 15 албан хаагчдыг хамруулсан.

38. Өргөдөл гомдлын талаар хийсэн ажил:

Байгууллагын хэмжээнд 2021 жилийн эцсийн байдлаар нийт 179 өргөдөл, гомдол ирснээс, хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 171, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 4, судлагдаж байгаа 4 өргөдөл, гомдол байна. Удирдлага дээр 6, Захиргааны хэлтэст 114, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 41, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 17 өргөдөл, гомдол цохогдсон байна. Өргөдлүүдийн дамжин ирсэн эх үүсвэрүүд НҮНТ-д бүртгэсэн 24, ННЗБ 42, 1800-1200 дугаараас ирсэн 51, 11-11 төвөөс ирсэн 54, гар утасны аппликейшнээр ирсэн 5, eservice 3 нийт 179 өргөдөл, гомдол ирсэн байна. Мөн байгууллагад цаасаар ирсэн өргөдөл, гомдлыг скайрнердаж egr.ulaanbaatar.mn-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 5 хоногт багтаан шийдвэрлэсэн 104, 10 хоногт багтаан шийдвэрлэсэн 40, 15 хоногт багтаан шийдвэрлэсэн 11, 30 хоногт багтаан шийдвэрлэсэн 15, хугацаа сунгасан 1 хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 13 цаг 45 минут байгаа нь түрүү жилийн хагас жилтэй харьцуулбал 7 хоног 5 цаг 38 минут болж багассан үзүүлэлттэй байна. Иймээс цаашид өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хоногийг бууруулах төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийг 5 хоногт нийт өргөдлийн 59% шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

График 15



- Жилийн эцсийн байдлаар өргөдөл гомдлын хандалтыг 2020 он- харьцуулвал Агаарын бохирдлын тухай өргөдөл гомдол 9,99% багассан, түлшний эрэлт нэмэгдсэнтэй холбогдуулан сайжруулсан түлшний талаар өргөдөл гомдол 0,57% багассан байна. Үзүүлэлтийг хүснэгт 5-д харуулав.

Байгууллагын 7 хоног тутамд шуурхай хуралд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн мэргэжилтнүүд тухай бүр нь анхааруулан дахин алдаа гаргахгүй сануулж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүрсэн амжилтаа бататган ажиллана, төлөвлөгөөний дагуу зөрчил дутагдлыг багасгахаар төлөвлөн ажиллаж байна.

Өргөдөл гомдлыг сайжруулах төлөвлөгөөнд дундаж хугацаа үзүүлэлтийг багасгах, өргөдөл гомдлыг хууль эрх зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хуулийн хугацаанд иргэнд танилцуулан албан бичгээр хариу өгч ажилласан. ERP өргөдөл гомдлын системд тогтмол хяналт тавьж, ирсэн бөгөөд өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь удирдлагад шилжүүлж байна.

График 16



39. Архив бүрдүүлэлт, хадгалалт ашиглалт:

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдээллийг улирлын болон хагас жилийн, сүүлийн хагас жилийн, бүтэн жилийн байдлаар гаргаж мэдээллэн ажилласан. 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ББНШК-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцэн 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдөр батлуулсан болно.

Мэргэжилтнүүдээс 2020 оны архивын баримт, материалыг хүлээн авч хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үйлдэж ажилласан. Бодлого хэрэгжилтийн хэлтэс, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсээс хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. 2018-2021 онд Нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэж баталсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг удирдлага болгон ажилласан.

Архиваас шаардлагатай баримт бичиг, архивын материал албан хаагчдад ашиглуулсан нийт 40 архивын баримт үзэж судлуулж бүртгэлийн дэвтэрт бүртгэн, баримт ашиглалтын хуудсыг бөглүүлэн ажилласан.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүнг хүлээн авч ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн комиссоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт”-ийн Улсын үзлэгийн дүнгийн тухай А/1340 дүгээр Захирамжийн гуравдугаар хэсэгт “Улсын үзлэгээр хангалтгүй дүгнэгдсэн байгууллагад арга хэмжээ, ажил сайжруулах” үүргийн дагуу “Нийслэлийн архивын газар”- аас хяналт шалгалт ирж заавар зөвлөмж өгсөн. Хяналт шалгалтаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу баримт бичиг найруулга зүй, зөв бичих дүрмийн алдааг хянан ажиллахыг мэргэжилтнүүдэд сургалтаар зөвлөсөн. Зөвлөмжийн дагуу үүрэгт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Архивын өрөөнд хадгаламжийн сангийн аюулгүй байдлыг ханган элс, шаардлагатай эд зүйлсийг байршуулсан. Батлагдсан ХХНЖ-ын дагуу хэлтсүүдийн 2020 оны цаасан суурьт баримтыг хүлээн авч ангилан баримтын бүрдлийг шалгаж архивлав.

40. Хэвлэмэл хуудасны ашиглалтын талаар:

Баримт бичгийн хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хэвлүүлсний дараагаар албан хэрэг хөтлөлтийн дагуу албан төсөл буулган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар нийт 1246 хэвлэмэл хуудас стандартын дагуу буулгасан. Үрэгдүүлсэн хэвлэмэл хуудас 60 ш байна. Хүснэгтээр хэвлэмэл хуудсын тайланг оруулав.

Хэвлэмэл хуудасны жилийн эцсийн зарцуулалтын мэдээ

Хүснэгт 41.

Д/д	Хэвлэмэл хуудасны нэр төрөл	Зарцуулсан хэвлэмэл хуудасны	Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны		Тайлбар
			Тоо	Индекс	
1	Зохион байгуулалт А5	612	19		
2	Зохион байгуулалт А4	276	20		

3	Тушаал А	242	21		
4	Тушаал Б	116			
Нийт		1246	60		

41. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт **114** тушаалд хууль, эрх зүйн талаас нь санал, зөвлөгөөг өгсөн;
- Хүний нөөц, боловсон хүчинтэй холбоотой нийт **60** тушаалын төслийг боловсруулж, хэлтсийн дарга нараар хянуулан, газрын даргаар баталгаажуулан ажилласан.

Эрх зүйн асуудлын хүрээнд дараах ажлыг хийгээд байна. Үүнд:

- Захиргааны хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 33 гэрээ;
- Бодлогын хэрэгжилтийн хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 49 гэрээ;
- Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 7 гэрээнд хууль эрх зүйн талаас нь санал, зөвлөгөөг өгч ажилласан.

Хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах эрх бүхий 6 албан тушаалтнуудаас 2020 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг тайлант хугацаа болох 2021 оны 2 сарын 15-ны өдрийн дотор гаргуулан авсан.

ЗХ-ийн даргын Удирдах албан тушаалд нэр дэвшээд буй 1 албан хаагчийн хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг Төрийн албаны тогтоолыг үндэслэн Авилгатай тэмцэх газарт 4 дүгээр сард албан бичгийн хамтаар хүргүүлэн хянуулж, газрын даргын 2021 оны Б/19 дүгээр тушаалаар ЗХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон болно.

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалд нэр дэвшээд буй 1 албан хаагчийн хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг Төрийн албаны тогтоолыг үндэслэн Авилгатай тэмцэх газарт 8 дугаар сард албан бичгийн хамтаар хүргүүлэн хянуулж, газрын даргын 2021 оны Б/33 дугаар тушаалаар Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон болно.

Захиргааны хэлтсийн даргаар ажиллаж байсан О.Алтангэрэлийн Төрийн албаны төв зөвлөлд 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр гаргасан гомдлын “Хариу тайлбар”-ыг 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр гарган өгч, хэрэг маргааныг байгууллагын талд шийдвэрлүүлэх дүгнэлтийг Төрийн албаны төв зөвлөлөөс 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гаргуулан ажилласан.

Мөн “Цайз” ХХК-ийн нэхэмжлэлтэй Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэл болон О.Алтангэрэлийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хариу тайлбаруудыг тус тус хуулийн хугацаанд нь гарган өгөөд байна.

42. Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Утаагүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Эрх шилжүүлэх, хөрөнгө гаргах тухай” А/639 дүгээр

тушаалаар баталгаажуулан захиран зарцуулах эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар:


1. Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41 дүгээр сургууль, 29, 71 дүгээр цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох
2. Баянзүрх дүүргийн 8, 16, 19 дүгээр хороо Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох
3. Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан, хүйтэн ус хангамжид холбох
4. Хан-Уул дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 дугаар сургууль, 209, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох дулаан дамжуулах төвийн нийт 4 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжүүлсэн. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дээрх 4 байршлын 36 халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг 100 % хийж гүйцэтгүүлсэн.

43. Төсөв санхүү, орлого бүрдүүлэлтийн чиглэлээр:

Shilendans.gov.mn сайтад сар бүр болон тухай бүр оруулах мэдээлэлд Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой тушаал болон хөрөнгө, зардал гаргах тушаал шийдвэрүүдийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим санд оруулж ажилласан. Тайлант хугацаанд:

- Бүтэц, орон тоо, албан хаагчдын цалинтай холбоотой А тушаал 3;
- Хөрөнгө, зардал гаргах тухай А тушаал 52-ыг байршуулж, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Зураг 26.



Шилэн дансанд мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байдал

3.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Хүснэгт 42.

№	Үйл ажиллагаа	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1.	2.	3.	4.
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн зургаа дугаар бүлэгт заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмыг баримтлан өөрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн төвшингээр шалгаруулах замаар нөхөн томилгоог хийж байна. Үүнд: 1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн	100%

		<p>27.1.1 заалтын дагуу тус газрын Орлогч даргын;</p> <p>2. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын газрын Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтсийн Хөдөлгөөнт эх үүсвэр хариуцсан ахлах мэргэжилтний;</p> <p>3. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Захиргааны хэлтсийн Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтний;</p> <p>4. 3. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний;</p> <p>5. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтсийн Агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн нарын Гүйцэтгэх ажилтны сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд 2021 оны 02 дугаар сард албан бичгээр хүргүүлсэн тусгай сонгон шалгаруулалтыг хийхээр захиалгаа өгч ажилласан. Сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дагуу хуулийн хугацаанд нь Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд албан бичгээр тухай бүрт мэдээлэн ажиллаж байна. (csc.gov.mn) болон (www.aprd.ub.gov.mn) сул орон тоог нийтэд мэдээлэн, сонгон шалгаруулалтыг зарлуулсан.</p>	
2	Албан тушаалын тодорхойлолтыг болосруулан, Төрийн албаны зөвлөлөөр батлуулах;	2021 оны эхний хагас жилийн байдлаар тус газар нь төрийн захиргааны 18, төрийн үйлчилгээний 18 (сайжруулсан түлшний үйлдвэр, дундын агуулахуудад 14 диспетчер), нийт 36 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд Төрийн албаны төв зөвлөлийн 2020 оны 103 дугаар тогтоолоор 17 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг, газрын даргын 2021 оны А/23 дугаар тушаалаар Байгууллагын ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинээр бий болсон төрийн үйлчилгээний 2 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан газрын даргаар 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр баталгаажуулсан.	100%
3	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын танилцуулга, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Газрын даргын тушаал, ажлын байрны тодорхойлолт зэргийг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн салбарт байршуулан тухай бүр мэдээлсэн.	100%
4	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг нийт албан хаагчдад танилцуулан, гарын үсэг зуруулж, холбогдох дүрэм журмыг мэдээллийн самбарт байршуулсан. (http://new.aprd.ub.mn/c/11/13)	100%
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар мэдээллэх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор дүгнэх дарааллыг тухайн хэлтсийн Ахлах мэргэжилтэн-Хэлтсийн дарга-Газрын дарга гэсэн дарааллаар явуулж байгаа бөгөөд "Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ыг цахим хуудсанд байршуулсан.	100%

44. “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ:

Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий 17 захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 7 хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 5 хурлын тэмдэглэлийн хэгжилтийг гарган цаасаар болон <http://monitoring.ub.gov.mn> цахим хуудсанд оруулж тайлагнасан.

45. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын чиглэлээр:


Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулсан бөгөөд Өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуралдуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн байгууллагын ажилтан, албан хаагчид солигдсонтой холбоотойгоор тухайн албан тушаал дээр өмч хариуцсан мэргэжилтэнд өмчийг шилжүүлэх, өмч актлах, жилийн эцсийн өмчийн тооллого хийх хэрэгцээ байгууллагад гарч үүнтэй холбоотойгоор дахин шинээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болж 2021 оны 11 сарын 26-ны өдөр шинэчлэн батлуулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Үйл ажиллагааны ил тод байдал:

Shilendans.gov.mn сайтад сар бүр болон тухай бүр оруулах мэдээлэлд Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой тушаал болон хөрөнгө, зардал гаргах тушаал шийдвэрүүдийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим санд оруулж ажилласан. Тайлант хугацаанд:

- Бүтэц, орон тоо, албан хаагчдын цалинтай холбоотой А тушаал 3;
- Хөрөнгө гаргах тухай А тушаал 2;
- Зардал гаргах тухай А тушаал 13-ыг тус тус байршуулж, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.



Зураг 34. Шилэн дансанд мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байдал

4.2 Хүний нөөцийн ил тод байдал:

Хүснэгт 43

№	Үйл ажиллагаа	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1.	2.	3.	4.
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	<p>Сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн зургаа дугаар бүлэгт заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмыг баримтлан өөрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулах замаар нөхөн томилгоог хийж байна. Үүнд:</p> <p>1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 заалтын дагуу тус газрын Орлогч даргын;</p> <p>2. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын газрын Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтсийн Хөдөлгөөнт эх үүсвэр хариуцсан ахлах мэргэжилтний;</p> <p>3. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Захиргааны хэлтсийн Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтний;</p> <p>4. 3. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний;</p> <p>5. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалтын дагуу тус газрын Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтсийн Агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн нарын Гүйцэтгэх ажилтны сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд 2021 оны 02 дугаар сард албан бичгээр хүргүүлсэн тусгай сонгон шалгаруулалтыг хийхээр захиалгаа өгч ажилласан. Сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дагуу хуулийн хугацаанд нь Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд албан бичгээр тухай бүрт мэдээлэн ажиллаж байна. (csc.gov.mn) болон (www.aprd.ub.gov.mn) сул орон тоог нийтэд мэдээлэн, сонгон шалгаруулалтыг зарлуулсан.</p>	100%
2	Албан тушаалын тодорхойлолтыг болосруулан, Төрийн албаны зөвлөлөөр батлуулах;	2021 оны эхний хагас жилийн байдлаар тус газар нь төрийн захиргааны 18, төрийн үйлчилгээний 18 (сайжруулсан түлшний үйлдвэр, дундын агуулахуудад 14 диспетчер), нийт 36 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд Төрийн албаны төв зөвлөлийн 2020 оны 103 дугаар тогтоолоор 17 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг, газрын даргын 2021 оны А/23 дугаар тушаалаар Байгууллагын ажил, албан	100%

		тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинээр бий болсон төрийн үйлчилгээний 2 албан тушаалын тодрхойлолтыг боловсруулан газрын даргаар 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр баталгаажуулсан.	
3	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын танилцуулга, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Газрын даргын тушаал, ажлын байрны тодорхойлолт зэргийг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн салбарт байршуулан тухай бүр мэдээлсэн.	100%
4	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг нийт албан хаагчдад танилцуулан, гарын үсэг зуруулж, холбогдох дүрэм журмыг мэдээллийн самбарт байршуулсан. http://new.aprd.ub.mn/c/11/13	100%
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар мэдээллэх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор дүгнэх дарааллыг тухайн хэлтсийн Ахлах мэргэжилтэн-Хэлтсийн дарга-Газрын дарга гэсэн дарааллаар явуулж байгаа бөгөөд "Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ыг цахим хуудсанд байршуулсан.	100%
Хэрэгжилтийн дундаж хувь: 100			

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай
5.1 Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 23 албан хаагч, 15 диспетчерийн ажлын үнэмлэхний загварыг гаргаж хэвлүүлэн албан хаагчдад түгээсэн.

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

Нэр: О.АЛТАНГЭРЭЛ
Албан тушаал: Захиргааны хэлтсийн дарга

Дарга **Ц.Цолмон**

№001

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

Санамж:
Энэхүү үнэмлэх нь "НАБТГ"-ын өмч бөгөөд үнэмлэхийг барьцаалах болон бусад дамжуулан ашиглуулахыг хориглоно

Хүчинтэй хугацаа ○2021 ○2022 ○2023 ○2024

Зураг 34. Албан хаагчдын ажлын үнэмлэх

5.1.1 Дарга, орлогч даргын нэрийн хуудасны эх бэлтгэж, хэвлүүлж өгсөн.



Зураг 35. Нэрийн хуудас хэвлүүлсэн байдал

5.2 “Дэм дэмэндээ” сайн үйлсийн аян зохион байгуулсан.

Дэлхий дахинд тархаад буй КОВИД-19 цар тахлаас үүдэн Монгол Улс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор хөл хорио тогтоож, ААНБайгууллагуудын үйл ажиллагаа хаагдаж, өрхийн орлого багасч зарим айл өрх, хүүхдүүд хоол тэжээлийн хомсдолд орох эрсдэлтэй нөхцөл байдал үүсч энэхүү хүнд эрсдэлтэй цаг үед Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгтэй зүйлээр нь нэгэндээ туслах “Дэм дэмэндээ” сайн үйлсийн аяныг санаачлан эхлүүлээд байгаа билээ. 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын хамт олны санаачлагаар сайжруулсан түлшний тээврийн компаниуд нэгдэж хөл хорионы үед хүнс нэн шаардлагатай байгаа эдийн засгийн чадамжгүй болсон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэй, өндөр настан зэрэг нийт 70 өрхөд хүнсний багц болон сайжруулсан түлшний тусламж үзүүлсэн.



Зураг 62. Хүнсний багц болон сажруулсан түлшний тусламж тараасан байдал



Зураг 63. Байгууллагын 1 албан хаагчид өргөө цагаан гэр бэлэглэсэн байдал

5.3 “Агаарын бохирдлыг бууруулах судлаачдын оролцоо” зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан.

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын санаачлагаар “Агаарын бохирдлыг бууруулахад судлаачдын оролцоо” сэдэвт зөвлөлдөх уулзалт 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Хангарди ордны хурлын зааланд зохион байгуулагдсан.

Уулзалтад Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З.Төмөртөмөө, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга Б.Пүрэвсүрэн, хэлтсийн дарга нар, Шинжлэх Ухааны Академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, академич Б.Авид, Шинжлэх Ухааны Академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн материал судлал, технологийн лабораторийн эрхлэгч, Академич Ж.Тэмүүжин, Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор С.Өнөрсайхан, Цаг уурч, доктор "Монгол Герман"-ы хамтарсан технологийн их сургуулийн Хүрээлэн буй орчны тэнхимийн эрхлэгч Г.Гантуяа нарын 10 гаруй эрдэмтэн судлаачид оролцон судалгаа шинжилгээнд суурилсан санал дэвшүүлж, илтгэл хэлэлцүүлсэн.


Тус зөвлөлдөх уулзалтын зорилго нь Нийслэл хотыг цэвэр агаартай, эрүүл аюулгүй орчин болгох, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, шинэлэг санал болон тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, цаашид хэрэгжүүлэхэд тулгамдсан, бэрхшээлтэй асуудлыг нэгтгэж, судалгаа, шинжлэх ухаанд суурилсан бодлого, хөтөлбөрийг боловсруулахад чиглэсэн зөвлөмж гаргахад оршино.



Агаарын бохирдлыг бууруулахад судлаачдын оролцоо” зөвлөлдөх уулзалт нь дэлхий нийтээр тархаад буй “COVID-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх дэглэмийн хүрээнд эрдэмтэн судлаачдыг хамруулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулж байгаа бөгөөд уулзалтаар “Амьсгал, зүрх судасны тогтолцооны өвчлөл, нас баралт, өвчний дарамтад гадаад орчны агаарын бохирдлын үзүүлэх нөлөөлөл”, “Авто тээврээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах судалгааны ажлын тойм” зэрэг сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлээ.

5.4 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206; 216; 217; 218 дугаар тогтоолоор баталсан журмуудыг хэрэгжүүлэх аргачлал, загварыг танилцуулсан 4 модуль цахим хичээлд хамрагдсан тухай:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бэлтгэж, <http://surgalt.unelgee.gov.mn> вэб хаягт байршуулсан “Журам шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Журам батлах тухай” Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралт “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-уудыг хэрэгжүүлэх аргачлал, загварыг танилцуулсан 4 модуль цахим хичээлийг судлаж нийт 23 албан хаагч гэрчилгээ авсан.



Зураг 65. Сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байдал

5.5 “Мод тарих үндэсний өдөр” хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан. 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын албан хаагчид ХУД-ийн 4 дүгээр хороонд байрлах 63 дугаар сургуулийн талбайд 200 суулгасан суулгасан.



Зураг 66. Мод тарьсан байдал

5.6 Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд:

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг Засгын газраас дэлхий нийтийг хамраад буй цар тахалтай холбоотойгоор тэмдэглэхгүй байхаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор байгууллагын ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлгийг эцэх эхээр нь дамжуулан хүргүүлсэн.



Зураг 67. Хүүхдийн баярын бэлэг бэлдсэн байдал

Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран албан хаагчдынхаа хүүхдүүд дундаас Авьяас чадвар, сурлага хөдөлмөрийн үнэлж Шилдэг хүүхэд медалиар 4 хүүхэд, Авьяас чадвар, урлаг, спорт, сурлага хөдөлмөрийн үнэлж Хүрэл медалиар 6 хүүхдийг тус тус шагнав.



Зураг 68. Албан хаагчдын хүүхдүүдэд медал гардуулсан байдал

5.7 НАБТГ-ийн дэргэдэх залуучуудын зөвлөл

Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалаар байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл” байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсгийн анхны хуралдаан өнөөдөр /2021.05.28/ болж Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын албан хаагчид, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга болон хамтран ажилладаг сайжруулсан түлшний тээврийн компанийн төлөөллүүд оролцож байна. Уг хуралдаанаар залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачилгыг дэмжих зорилгоор төр болон хувийн хэвшлийн түлшлэлийг сайжруулахаар залуу үеийн төлөөллүүдтэй хамтран ажиллахаар болсон.



Зураг 69. ЗХЗ-ийн уулзалт

• МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 заалт, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн манай байгууллагатай холбогдолтой 7 заалт, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд туссан 1 заалтын биелэлтийг гарган цаг хугацаанд нь холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан. Мөн НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, НИТХ-ын 1 тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хугацаанд нь нэгтгэн гаргаж ажилласан.

• Утаагүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилтийн хуваарийг боловсруулан НЗДТГ-ын Төрийн сангийн хэлтсээр хянуулан НЗД-аар батлуулсан.

• “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” болон “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгах санал, үндэслэл, саналын тайлбар, салбарын хөгжлийн өнөөгийн байдал, дунд хугацааны чиг хандлагын танилцуулга зэргийг тус тус боловсруулан НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

• Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Төрийн албаны тухай хууль, “Агаарын тухай хууль”, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж Газрын удирдлага, НЗД-аар батлуулахаар Захиргааны хэлтэст хүлээлгэн өгсөн.

• Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын нэвтрүүлж буй байгаль орчинд ээлтэй, шинэлэг дэвшилтэт технологи,

бодит үр дүн үзүүлж буй төслүүдтэй танилцах, хамтран ажиллах санал солилцох зорилгоор “Дэвшилтэт техник технологи руу шилжүүлэх замаар улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 05-р сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтын үеэр сэргээгдэх эрчим хүчний технологиудын ашиглалт, бүх төрлийн түлшнээс ялгарах бохирдлыг бууруулах нано технологи, дотоод болон гадаад орчны үнэрийн бохирдлыг бууруулах технологи, хийн халаалтын шийдэл, орон байрыг дулаан тусгаарлагч материал ашиглан дулааны алдагдлыг багасгах, цахилгаан халаалт ашигласнаар агаарын бохирдлыг бууруулах зэрэг сэдвүүдээр 8 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллүүд илтгэл танилцуулж, хэлэлцүүлсэн.

Зураг 70.



Зураг 44. Цахимаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байдал

- Дэлхийн Хүрээлэн буй орчны өдөр 6-р сарын 5-ныг тохиолдуулан “Хүрээлэн буй орчны инженерчлэл” сэдэвт оюутны эрдэм шинжилгээ, онол практикийн дөрөвдүгээр бага хурлыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Монголын Хүрээлэн буй орчны инженер мэргэжилтнүүдийн нийгэмлэгээс санаачлан тус байгууллага дэмжин, хамтран зохион байгуулсан. Хуралд их дээд сургуулиудад хүрээлэн буй орчны инженерчлэл, хими, химийн инженерчлэл, механик инженер, уул уурхайн инженер, материалын технологи, цаг уур, ус судлал, хүрээлэн буй орчин судлал, ойн аж ахуй, үйлдвэрийн экологи зэрэг хүрээлэн буй орчинтой холбоотой инженер технологи, шинжлэх ухааны чиглэлүүдээр бакалавр, магистрын түвшинд суралцаж буй оюутнууд оролцсон. Уг үндэсний хурлын хүрээнд 2021 оны 07-р сарын 25-ны өдөр “Орчны бохирдол ба шийдэл” олон нийтийн шилдэг бүтээлийн уралдаан, 2021 оны 09-р сарын 09-ны өдөр салбарын ажилтнуудын уулзалт, хүрээлэн буй орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа сурталчлан таниулах үзэсгэлэн тус тус зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

- Газрын даргын 2021 оны 03-р сарын 16-ны өдөр А/24 дугаар тушаалаар “Сайжруулсан түлшний хэрэглээний сэтгэл ханамжийн болон эдийн засгийн үр ашгийн судалгаа” хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суух гэр хорооллын айл өрхүүдийн сайжруулсан түлшийг хэрэглэж буй үеийн сэтгэл ханамжийн судалгааг түүхий нүүрс хэрэглэж байсантай харьцуулан гаргах, сайжруулсан түлш хэрэглэснээр айл өрхөд гарсан эдийн засгийн өгөөж үр дүнг түүхий нүүрс түлж байсан үетэй харьцуулах судалгаа хийх ажлын даалгаврыг боловсруулан, сонгон шалгаруулалт явуулж “Корпорэйт Трэйнинг” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Гэрээт ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажил хийгдэж байна.


- “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх 6 төсөл арга хэмжээнээс 4 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмж мэдэгдлийг хүргүүлсэн. 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлаж тендерийн материал хүлээн авч байна.

- Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч З. Төмөртөмөөгийн өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 1 удаа, НИТХ-д 2 удаа ЗГ-ын 2018 оны 62-р тогтоолын хэрэгжилтийг тус тус танилцуулж, шийдвэр гаргуулах асуудал боловсруулж хэлэлцүүлсэн.

- “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг дэвшилтэт технологи бүхий цахилгаан халаагуураар хангах” № [НАББГ- 2018/08] гэрээт ажлыг гүйцэтгэсэн “Пүүл ресурс” ХХК-ий бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн ажлын баталгаат засварын хугацаа дуусгавар болсон тул барьцаа хөрөнгийг чөлөөлөх ажлыг зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг байгуулж, холбогдох баримтыг бүрдүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж барьцааг чөлөөлсөн.

- Нийслэлийн засаг Даргын тамгын газар болон " Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ хамтран шинэ коронавирусын тархалттай холбоотой үүссэн онцгой нөхцөл байдлын үед Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээ тасралтгүй, түргэн шуурхай, уян хатан ажиллах боломж нөхцлийн талаар танилцуулах "ЗӨВ МЕНЕЖМЕНТ- ЗӨВ ТОГТОЛЦОО" стандарт танилцуулах цахим сургалтад 2021 оны 01 дугаар сарын 27-ны өдөр тус хэлтсийн 2 мэргэжилтэн хамрагдсан.

Зураг 71.



Зураг 45. “ЗӨВ МЕНЕЖМЕНТ- ЗӨВ ТОГТОЛЦОО” стандарт танилцуулах цахим сургалтад хамрагдаж буй байдал

- Байгаль орчин, Аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Япон улсын Байгаль орчны яам (ЯБОЯ), Хилийн чанад дах Байгаль орчны хамтын ажиллагааны төв (ОЕСС), Нийслэлийн Захирагчийн алба, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албанаас 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Нүүрсэн галлагаатай зуухыг хийн технологи руу шилжүүлэх замаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах нь” сэдэвт цахим семинарт дэд дарга Ц.Цолмон, мэргэжилтэн Г.Уранцэцэг нар оролцож, ахлах мэргэжилтэн М.Отгонбаяр “Халаалтын зуухаас агаар, орчны нөлөөллийг бууруулах” сэдвээр илтгэл тавьж оролцсон.

- Тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Цацрал 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Японы Олон улсын “ЖАЙКА” байгууллагаас зохион байгуулсан “Агаарын чанарын менежмент” сэдэвт 2 хэсэгт сургалтын эхний хэсэгт 14 хоногийн хугацаанд онлайнгаар хамрагдаж сертификат авсан.

- 2021 оны 03 дугаар сарын 19–нд зохион байгуулагдсан Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад төрийн байгууллагуудын оролцоо хамтын ажиллагаа-зөвлөлдөх цахим уулзалтад Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Бямбацэцэг оролцсон.

- Японы Жайка олон улсын байгууллагаас зохион байгуулсан 2021 оны 3 дугаар сарын 26-наас 05 сарын 27-ны хооронд нийт 8 удаагийн цахим сургалтад тус хэлтсийн 3 мэргэжилтэн хамрагдаж эх үүсвэрээс үүдэлтэй агаар бохирдуулагч бодисын ялгарлыг тооцох, үйл ажиллагааны өгөгдөл цуглуулах, мөн ялгарлын коэффициент тооцоолоход шаардлагатай мэдээллийг нэгтгэх, боловсруулах зэрэг арга зүйн болон техникийн чадвараа нэмэгдүүлэн, цаашид бие даан тооцоолол хийх чадвар эзэмшсэн.



Зураг 72. Сургалтад хамрагдсан байдал

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- Чанарын удирдлагын стандарт ISO9001:2015 нэвтрүүлэх .
- НЗДТГ-ын дэргэдэх Сургалт судалгааны төвтэй хамтран албан хаагчдад зориулан сургалт авах, албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх.
- Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчилж, албан хаагчдын зарим нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд нэмэлт өөрчлөлтийг хийх

ТАНИЛЦСАН:

НАОБТГ-ЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:МЭРГЖИЛТЭН



Б.ПҮРЭВСҮРЭН

Ж.БАЛЖИННЯМ

Т.ЭНХМАА